

Мэс заслын тусламж үйлчилгээний журам 2023 он



МЭС ЗАСЛЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Баримтжуулсан мэдээллийн дугаар:

Хувилбарындугаар: 2

Хүчинтөгөлдөр болсон огноо: 2022 он

Баримт бичгийг хариуцах нэгж			
Баримт бичгийн нууцлалын зэрэглэл:	Дотоод	Баримт бичгийн түвшин	2
		Албан тушаал	Гарын үсэг
Боловсруулсан:	ЭЭДЭ ЭТҮЧАБА-ны дарга ХНТ эрхлэгч САЗ	Д.Болормаа Ц.Лувсандамдин В.Очирдорж Ч.Бадамсүрэн	<i>Баяр</i> <i>Ц.Лувсандамдин</i> <i>В.Очирдорж</i> <i>Ч.Бадамсүрэн</i>
Санал өгсөн:	Зөвлөх багийн гишүүн Сувилахуйн менежер	Л.Алтантөгс Н.Баярсайхан Ж.Баярсайхан Б.Алтангана Б.Болортуяа	<i>Л.Алтантөгс</i> <i>Н.Баярсайхан</i> <i>Ж.Баярсайхан</i> <i>Б.Алтангана</i> <i>Б.Болортуяа</i>
Хянаж батласан:		БОЗТ-ийн захирал	<i>Б.Болортуяа</i>

АГУУЛГА

1.0	ЗОРИЛГО
2.0	ХАМРАХ ХҮРЭЭ4 Error! Bookmark not defined.
3.0	НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГС, ИШ ТАТСАН БАРИМТ БИЧИГ
3.1	Нэр томъёо
3.2	Товчилсон үгс Error! Bookmark not defined.
3.3	Иш татсан буюу хамааралтай баримт бичиг5 Error! Bookmark not defined.
4.0	ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА (RACI матриц)6,6
5.	БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО	
6.	Процедур Error! Bookmark not defined.
6.1	Төлөвлөгөөт мэс засалд өвчтөнг бэлтгэх
6.2	Яаралтай мэс засалд оруулах
6.4	Хагалгаанытөлөвлөгөө боловсруулж, баталгаажуулах
6.5	Хагалгааны хэсэгт орохын өмнө
6.6	Мэс заслын багийнхны үйл ажиллагаа
6.7	Аюулгүй орчныг бүрдүүлэх
6.8	Эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдал
6.9	Ажлын байрны ёс зүй
6.10	Гадаадын мэргэжилтнийг ажиллуулах журам
6.11	ХДХВ -тэй болон эрсдэлтэй халдвартай эмчлүүлэгч хагалгаанд орох үед баримтлах зарчим
6.12	Бусад эмнэлэгтэй хамтран ажиллах
6.13	Мэс заслын тасагт гадны хүн нэвтрэх журам /хүнд өвчтөний ар гэрийхэн, цагдаагийн ажилтан/
6.14	Журам зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээ

НЭГ. ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЛЭГЧ

1.1 Энэхүү журмын зорилго нь БОЭТ-н Мэс заслын тусламж үйлчилгээний хэвийн ажиллах нөхцөл, халдвар хамгаалал, технологийн бэлэн байдлыг хангах,

1.2 Мэс заслын тусламж үйлчилгээг эмчлүүлэгчдэд тэгш хүртээмжтэй, хүнлэг энэрэнгүй, аюулгүй хүргэж БОЭТөвд давтан мэс засал, мэс заслын дараах хоёрдогч хүндрэлийг бууруулах

1.3 Эмч эмнэлгийн мэргэжилтний ажил үүргийг оновчтой зохион байгуулах, сахилга, дэг журам тасаг нэгжийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулахад тус тус оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЛЭГЧ

2.1 Энэхүү мэс заслын тусламж үйлчилгээний журмыг БОЭТ-ийн мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлэх эрх бүхий тасаг нэгжүүд дагаж мөрдөнө.

2.2 БОЭТ-ийн нийт ажилчид дагаж мөрдөнө.

ГУРАВ. НЭР ТОМЪЁО, ТОВЧИЛСОН ҮГС, ИШ ТАТСАН БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

3.1 НЭР ТОМЪЁО

Нэр томьёо	Тайлбар
Мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлдэг тасгуудын амбулаторийн эмч	Чих хамар хоолой, нүд, эрүү нүүрний мэс засал, ерөнхий мэс засал, эх барих эмэгтэйчүүдээр төрөлжсөн нарийн мэргэжлийг эзэмшсэн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй, тухайн цаг үед амбулаторийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эмч
Оператор эмч	Мэс заслыг удирдаж, мэс заслын багийн үйл ажиллагааг зохион байгуулах, төрөлжсөн нарийн мэргэжлийг эзэмшсэн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй эмч
Мэс заслын туслах эмч	Оператор эмчийн удирлаган дор мэс заслын үйл ажиллагааг явуулах, оператор эмчид туслах хамтрах ажиллах үүрэг бүхий төрөлжсөн нарийн мэргэжлийг эзэмшсэн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй эмч
Мэс заслын сувилагч	Мэс заслын төрөлжсөн нарийн мэргэжил эзэмшсэн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй сувилагчийг
Мэдээгүйжүүлгийн эмч	Эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлгийн төрөлжсөн нарийн мэргэжлээр мэргэшсэн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй эмч

Мэс заслын тусламж үйлчилгээний журам 2023 он

Мэдээгүйжүүлгийн сувилагч	Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлгийн төрөлжсөн нарийн мэргэжил эзэмшсэн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй сувилагчийг
Өвчний түүх	Эмнэлэгт хэвтэн үйлчлүүлэгчдэд хийгдэж буй оношилгоо, эмчилгээний явц, үр дүнг тусгасан БОЭТөвийн нууцийн зэрэгт хамаарах хуулийн, сургалт эрдэм шинжилгээний баримт бичиг
Хяналтын хуудас	Тухайн нэгжийн үйл ажиллагааг батлагдсан дүрэм журам, зааврын дагуу хийх үйлдлийг тоочин тэмдэглэх хянах шалгуур хуудас
Сэрээх өрөө	Мэс заслын өрөөнөөс гарч ирсэн үйлчлүүлэгчийн биеийн байдлыг хянах, тогтворжуулах зорилготой дамжин өнгөрөх өрөө
Хяналтын сувилагч	Мэс заслын төрөлжсөн нарийн мэргэжил эзэмшсэн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй, мэс заслын хэсгийн орох гарах үйл ажиллагааг ерөнхийд нь зохицуулагч сувилагч
Хамтарсан үзлэг, зөвөлгөөн	Нэг мэргэжлийн болон өөр бусад нарийн мэргэжлийн нэгээс дээш эмч нар оролцон тухайлсан нэг эмчлүүлэгчийн биеийн байдал, эмчилгээ оношилгооны асуудлаар хэлэлцэн дүгнэлт шийдвэр гаргахыг
Мэс заслын төлөвлөгөө	Мэс засал эмчилгээ шаардлагатай үйлчлүүлэгчийн бүхий л шинжилгээ, биеийн ерөнхий байдлыг бүрэн үнэлж мэс засалд оруулах шийдвэр гаргасны дараа мэс засалд орох хугацаа, мэс заслын онош, мэс заслын багийнхнийг тодорхой бичиж гарган батлуулсан хуваарь
Тэмдэглэгээ хийх - Flagging	Мэс засалд орж байгаа эмчлүүлэгчийн өвчний түүх, мэс заслын өрөөнд эмэнд тэсвэржсэн бичил биетний халдвар/колонизаци-тай, В С вирусын халдвартай, ХДХВ, тэмбүү гэх мэм халдвартай, эсвэл сэжигтэй гэсэн тэмдэглэгээ хийснээр эрүүл мэндийн байгууллагын ажилтанд сэрэмжлүүлэх дохио өгөх зорилготой үйл явц
Сэрээх өрөөнөөс шилжүүлэх	Эмчлүүлэгчийн амин үзүүлэлт тогтвортой үед хэвтэн эмчлүүлэх тасагруу шилжүүлэх үйл явц
Монитор	Эмчлүүлэгчийн амьсгал, зүрх судасны үйл ажиллагааг автоматаар хянах эмнэлгийн тоног төхөөрөмж
Гистологийн эд	Мэс засал болон мэс ажилбарын үед онош тодруулах баталгаажуулах зорилготойгоор эмчлүүлэгчийн бие эрхтэнээс авсан эд
Зохиомол амьсгалын аппарат	Ерөнхий мэдээ алдуулалтын үед зохиомлоор амьсгалуулах
Интубац	Цагаан мөгөөрсөн хоолойд гуурс тавихыг хэлнэ.
Экстубаци	Цагаан мөгөөрсөн хоолойд гуурс авахыг хэлнэ.
Коагуляци	Түлэх зүсэх үйлдэл бүхий цус тогтоох багаж

Отсос	Соруулах үйлдэл бүхий багаж хэрэгсэл
-------	--------------------------------------

3.2 Товчилсон үгс

- **БОЭТ**- Бүсийн оношилгоо эмчилгээний төв
- **ЭЭДЗ** -Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал
- **ТЗ**- БОЭТ-ийн захирал
- **САЗ** - Сувилахуйн арга зүйч
- **ЧАБА** - Чанар аюулгүй байдлын алба
- **ХСХА** - Халдварын сэргийлэлт хяалтын алба
- **ХДХВ** - Хүний дархлал хомсдолын вирус
- **ЭБЭК** – Эх барих эмэгтэйчүүдийн клиник
- **ЧХХНЭНМЗ**- Чих хамар хоолой нүд эрүү нүүрний мэс засал
- **ЭЭХНТЭ** – Эрчимт эмчилгээ хагалгааны нэгдсэн тасгийн эрхлэгч
- **ЭХО** – Эхосонография
- **КТГ** – Компьютер томография
- **CRM**- Мэс заслын үед зураг авах, харах рентгэн аппарат
- **ЭТҮХХ**- Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар
- **ХСХ**- халдварын сэргийлэлт хяналт
- **ЕМА**- ерөхний мэдээ алдуулалт
- **ХМА**-хэсгийн мэдээ алдуулалт
- **НХМ**- нугасны хөндийн мэдээ алдуулалт

3.3 Холбогдолтой буюу иш татсан баримтжуулсан мэдээлэл

1. Эрүүл мэндийн тухай хууль 2011.05.05
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль 2016.04.22
3. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
4. MNS 5095: 2017 Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт
5. MNS/ISO 9001:2016 Чанарын удирдлагын тогтолцоо стандарт
6. MNS4621:2008 Оношилгоо эмчилгээний гардан үйлдлийн стандарт
7. MNS 6205:2010 Нугасны хатуу хальсны гадна хөндийн мэдээгүйжүүлэг
8. MNS6206:2010 Цагаан мөгөөрсөн хоолойн гуурстай ерөнхий мэдээгүйжүүлэг
9. MNS 6203:2010 Уушигны мэс заслын үеийн мэдээгүйжүүлэг
10. MNS 6204:2010 Нугасны хөндийн мэдээгүйжүүлэг
11. ЭМС-ын 2019.12.06 А\554 тоот тушаал Эрүүл мэндийн байгууллагын магадлан шинжлэх шалгуур батлах тухай
12. ЭМС-ын 2019.12.30 А\611 тоот тушаал Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам бүртгэлийн маягтыг шинэчлэн батлах тухай
13. ЭМС-ын 2019.11.29 А\536 тоот тушаал Дүрэм жагсаалт батлах тухай
14. ЭМС-ын 2019.11.29 А\537 тоот тушаал Заавар батлах тухай
15. ЭМС-ын 2019 оы А\505 тоот тушаал

16. ЭМС-ын 2019.09.04 А\406 тоот тушаал Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай
17. ЭМС-ын 2019.11.29 А/538 тоот тушаал Олон эмэнд тэсвэржсэн зарим бичил биетний тандалт, халдвараас сэргийлэх, хянах заавар батлах тухай
18. ЭМС-ын 2019.11.29 А/539 Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг тандах заавар батлах тухай
19. ЭМС-ын 2020.07.06 А/373 тоот тушаал Журам шинэчлэн батлах тухай
20. Байгууллагын дотоод журам
21. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний нийтлэг журам 1 хувилбар

ДӨРӨВ. ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА (RACI матриц)

Хүснэгт1- Процессын үүрэг хариуцлагын матриц

Албан тушаал Процесс	Амбулаторийн эмч	Мэдээгүйжүүлгийн эмч	Зөвлөх эмч нар	ЭЭХНТЭ	Тасгийн сувилагч	Фильтер сувилагч	Мэдээгүйжүүлгийн сувилагч	Мэс заслын сувилагч	Мэс заслын эмч	Туслах сувилагч	Үйлчлэгч	Сэрээх өрөөний сувилагч	ЭЭДЗ	ЧАБА
Эмчлүүлэгчийг оношилж мэс засалд оруулах шийдвэр гарган шинжилгээ бүрдүүлж төлөвлөгөөнд оруулах	AR	C	C	I					AR					
Мэс заслын төлөвлөгөө гарган батлуулах	C	C	C	AR	I	I	I	I	C				C	
Мэс заслын өмнө эмчлүүлэгчийг мэс засалд бэлтгэх	I	C			R	R	C	C	R	R				
Мэс заслын өрөө болон тоног төхөөрмжийн аюулгүй байдлыг хангах		R				R		RA	C		C	C	I	I
Эмчлүүлэгчийг мэс заслын		C			C	RA	C		C	C				

өрөөнд төлөвлөгөө хуваарийн дагуу оруулах														
Эмчлүүлэгчийн мэдээллийг нягталж өвчний түүхтэй тулгаж хяналтын хуудас хөтлөн, сэтгэл зүйн бэлтгэл хийж орон дээр байрлуулж уян зүү тавих	I				C	R	AR	RA	C	C			I	I
Мэдээгүйжүүлэг хийж мэс засал эхлэх зөвшөөрөл өгөх		C	I	I	I	C	C	C	AR	C	C	I	I	I
Мэс засалд хэрэглэгдэх багаж тоног төхөөрөмж, ариун материалыг бэлтгэж мэс засалд туслах		I				I	C	RA	C	C	C			
Мэс заслын эмч нарын хувцас өмсөлт гар угаах, ариун материалтай харьцах үйл явцыг хянаж, хувцаслах						C	C	AR	C	C	C			
Мэс заслыг эхлүүлж, дуусах хүртэлх үйл явцыг гардан гүйцэтгэх		C	I			C	C	C	AR	C	C		I	I
Мэс заслын шархыг хааж ариун боолт хийж мэс заслыг дуусгах		I			I	I	C	RA	RA	C	C	I		RA C
Мэдээгүйжүүлгийг дуусгаж эмчлүүлэгчийг сэрээх өрөөнд оруулах		RA		RA	I	C	RA	C	C	C	C	C		I

Мэс засалд хэрэглэгдсэн бохир материалыг тоолж, мэс заслын үед авсан эд эрхтэнг шинжилгээнд өгөх устгах, хог хаягдлыг ялган ангилах устгах						I	C	R	A	I	C	R	A	C			I
Мэс заслын өрөөг стандартын дагуу цэвэрлэж дараагийн мэс засалд бэлтгэх							I	I	I	C	R	A	C				

(R- гүйцэтгэх, A- хариуцах, C- хамтран ажиллах, I-мэдээлэлтэй байх)

ТАВ. МЭС ЗАСЛЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД БАРИМТЛАХ НИЙТЛЭГ ЗАРЧИМ

- 5.1 Мэс заслын тусламж үйлчилгээг хүнлэг энэрэнгүй, аюулгүй, хугацаа алдалгүй хүргэх
- 5.2 Мэс заслын тусламж үйлчилгээг эмчлүүлэгчийн эрэлтэд нийцсэн батлагдсан стандарт хэм хэмжээний хүрээнд хүргэх
- 5.3 Орчин үеийн анагаах ухааны нотолгоот дэвшилтэт арга, шинэ технологийг тусламж үйлчилгээндээ тасралтгүй нэвтрүүлнэ.
- 5.4 Эмчлүүлэгч , түүний гэр бүлийн оролцоог дэмжсэн тусламж үзүүлж тэдний аюулгүй байдал, эрх ашиг, зан заншлыг хүндэтгэж, нууцыг хадгална.
- 5.5 Давтан мэс засал, мэс заслын дараах хүндрэлээс сэргийлэх тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана.
- 5.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал, ХСХ зааврыг мөрдөнө

ЗУРГАА. МЭС ЗАСЛЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ОРОЛЦОХ МЭРГЭЖИЛТНИЙ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 6.1 **Мэс заслын тусламж бүхий тасгийн зөвлөх эмчийн үүрэг хариуцлага**
 - Мэс засал эмчилгээ хийлгэх гэж байгаа эмчлүүлэгчийн мэс заслын заалт бэлтгэл, мэс заслын эрсдэл, хүрц арга техникийг тодорхойлох
 - Мэс заслын үед зөвөлгөө өгөх
 - Өөрийн хариуцсан эмчлүүлэгчийн эмчлэгч эмчийн үүрэг хүлээнэ
 - Мэс заслын тусламж үзүүлдэг өөрт харъяалагдах тасаг нэгжүүдэд эмчлэгдэж буй мэс заслын тусламж шаардлагатай эмчлүүлэгчид хамтарсан үзлэг хийж, эмчилгээ , оношилгоо асуудлыг шийдвэрлэнэ.
 - Мэргэжлийн багийн хурлыг улирал тутамд зохион байгуулж, хурлын үйл ажиллагааг удирдана
 - Тасгийн эмч нарын тойрон болон хамтарсан үзлэгийг хийж удирдана.
 - Ховор тохиолдол, шинэ технологи болон онц хүнд байдлаас амь насыг аварсан тохиолдлуудыг зөвлөх эмчийн багаар хянан хэлэлцүүлнэ.

- Мэс заслын тусламж үйлчилгээнд оролцож байгаа баг хамт олон ижил мэргэжилтнээ хүндэтгэх
- Эмч нарын хамтарсан болон тойрон үзлэг хийж дүгнэлт шийдвэрийг гэр бүлийнхэнд танилцуулах, зөвөлгөө мэдээлэл өгнө.
- Тасгийн эмч нарыг тасралтгүй сургалтанд хамрагдах, эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх, бие даан мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.
- Хууль журам заагдсан бусад үүрэг хариуцлага

6.2 Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэг,яаралтай тусламжийн зөвлөх эмчийн үүрэг

- Шаардлагатай тохиолдолд мэс засал эмчилгээ хийлгэхээр бэлтгэсэн эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлж мэдээгүйжүүлэгийн асуудлыг шийдвэрлэх
- Мэдээгүйжүүлгийн эмч нартай хамтарсан үзлэг зөвлөгөөн зохион байгуулж мэдээгүйжүүлэг ,эмчилгээний асуудлыг шийдвэрлэх
- Ховор тохиолдол, шинэ технологи болон онц хүнд байдлаас амь насыг аварсан тохиолдлуудыг зөвлөх эмчийн багаар хянан хэлэлцүүлнэ.
- Эмч нарын хамтарсан болон тойрон үзлэг хийж дүгнэлт шийдвэрийг гэр бүлийнхэнд танилцуулах, зөвөлгөө мэдээлэл өгнө.
- Тасгийн эмч нарыг тасралтгүй сургалтанд хамрагдах, эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх, бие даан мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.
- Хууль журам заагдсан бусад үүрэг хариуцлага

6.3 Мэс заслын тусламж бүхий тасгийн эрхлэгчийн үүрэг хариуцлага

- Мэс засалд орох эмчлүүлэгчийн өвчний түүх нээхийг эмчлэгч эмчид цохолтыг хийж, шинжилгээ бүрдэлт түүний өөрчлөлтөнд дүгнэлт хийж мэс заслыг батална.
- Мэс заслын бэлтгэл , мэс заслын явцад эмчилгээний явцын болон төгсгөлийн хяналтыг хийнэ.
- Мэс заслын тусламж үзүүлдэг өөрийн харъяа тасгийн бүхий л үйл ажиллагааг удирдан, зохион байгуулна
- Шаардлагатай тохиолдолд эмчлэгч эмчийн хүсэлтээр үйлчлүүлэгчийг үзэж эмчилгээ оношлогоонд зөвлөгөө өгнө.
- Тасагт эмчлэгдэж байгаа үйлчлүүлэгчдийн эмчилгээ сувилгаа, тасгийн ХСХ дэглэмийн мөрдөлтөнд тогтмол хяналт тавьж, тасгийн эмч мэргэжилтэнд заавар зөвлөгөө өгөх.
- Эмчлүүлэгч, түүний гэр бүлийнхэнд эмчилгээ үйлчилгээтэй холбоотой мэдээллийг өгч болно.
- Хууль журам заагдсан бусад үүрэг хариуцлага

6.4 Хагалгааны нэгсэн тасгийн эрхлэгч эмчийн үүрэг

- Мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасгийн зохион байгуулалт үйл ажиллагааг удирдан чиглүүлж хянан

- Шаардлагатай тохиолдолд мэс засалд орох эмчлүүлэгчийг үзэж биеийн байдалд дүгнэлт хийх мэс заслын эрсдэлийг тогтоох хянах
- Мэс заслын төлөвлөгөөг нарийвчлан гаргаж баталгаажуулна.
- ХНТасгийн мэс заслын үеийн цагийн менежментийг хянан, зохицуулна.
- Мэдээгүйжүүлгийн эмч сувилагчийн үйл ажиллагаанд хяналт тавина.
- Мэдээгүйжүүлгийн хүндрэл үүсвэл түүнийг биечлэн оролцож удирдан шийдвэрлэнэ.
- Эмч , сувиалгч нарт ААЗааварчилгааг өглөө бүр өгч баталгаажуулна.
- Хууль журам заагдсан бусад үүрэг хариуцлага

6.5 Мэдээгүйжүүлгийн эмчийн үүрэг хариуцлага:

- Эмчлүүлэгчийг бүрэн үзлэг хийж өвчтний түүхийг хөтлөж баримтжуулна.
- Шаардлагатай шинжилгээ, нэмэлт ажилбарыг төлөвлөж гүйцэтгэнэ.
- Эмчлүүлэгчийг амьсгал, цус эргэлтийн байдлыг 10 минут тутамд үнэлж дүгнэнэ.
- Эмчлүүлэгчийн эмчилгээг хянан сувилагчид зааварчилгаа өгч удирдан ажиллана.
- Халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан, сувилагч, туслах сувилагч нарт хяналт тавьж ажиллана.
- Эмчлүүлэгч, түүний гэр бүлийнхэнд мэдээгүйжүүлэгтэй холбоотой мэдээллийг өгнө.
- Мэдээгүйжүүлэгтэй холбоотой хяналтын хуудас, маягыг бүрэн хөтлөнө.
- Сэрээх өрөөний сувилагчийн үйл ажиллагаанд хяналт тавина, хамтран хянаана.
- Хууль журам заагдсан бусад үүрэг хариуцлага

6.6 Мэс заслын эмчийн үүрэг, хариуцлага

- Эмчлүүлэгчийг мэс засалд орохоос өмнө хагалгааны тактикийг боловсруулан тасгийн эрхлэгч, зөвлөх эмч нартай зөвшилцөн шийднэ.
- Туслах эмч нарт хагалгааны төлөвлөгөөг танилцуулж мэдээллийг нэгтгэнэ.
- Хагалгааны өмнө эмчлэгч эмч мэс заслын хийх тал, хийх зүслэгийг арилдаггүй харандаагаар эмчлүүлэгчийн биеийн хэсэгт тэмдэглэнэ.
- Эмчлэгч эмч болон мэс засалд оператороор орох эмч төлөвлөгөөт хагалгаанд хэрэглэгдэх нэмэлт багажийг хагалгааны сувилагчид 1 өдрийн өмнө урьдчилан хэлж бэлтгүүлсэн байна.
- Мэс заслын өрөөнд өвчний түүх, шаардлагатай шинжилгээний хариу рентген зураг зэргийг бэлтгэнэ.
- Хагалгааны үед гарч болох хүндрэлийг тооцож, шаардлагатай тоног төхөөрөмж багаж , эм хэрэгслийн бэлэн байдлыг хангуулна.
- Хагалгаанд оператор эмчээр орж байгаа үед мэс заслын багийг удирдана.
- Туслах эмчийн хийж чадах хагалгааг өөрийн хяналтын дор хийлгэж болно.
- Эмчлүүлэгчийг хагалгааны ширээн дээр зөв байрлуулах, ивээс бэхэлгээг аюулгүй зөв хийсэн байдалд хяналт тавьж, шалгана.
- Хагалгаанд хэрэглэгдэх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн /дуран, коагуляци, отсос г.м / байрлуулалт, хэрэглэх нөхцөл, технологийн дагуу ажиллагаанд хяналт тавина.

- Хагалгааны үед төлөвлөсөн тактик еөрчлөгдөх, өвчтөн хүндэрсэн тохиолдолд багаараа хэлэлцэж, нэмэлт шинжилгээ /ЭХО, рентген, дуран/ авах, зөвлөх эмчийн зөвөлгөө авах г.м асуудалд шийдвэр гаргана.
- Хагалгааны дараах эмчилгээний бүх асуудлыг хариуцна.
- Хагалгааны тэмдэглэлийг өвчний түүхэнд бичнэ.
- Хагалгааны дараа эмчлүүлэгч хүнд үед эрчимт эмчилгээний тасагт шилжүүлэх болон эмчилгээний талаар мэдээгүйжүүлэгч болон тухайн тасгийн эрхлэгчтэй ярилцаж шийдвэрлэнэ.
- Эрчимт эмчилгээнд орох болсон заалтыг өвчний түүхэнд тусгана.
- Мэс заслын дараа эмчлүүлэгч ,ар гэрт мэс заслын явц үр дүн , авсан эд эрхтний талаар мэдээлэл өгнө.

6.7 Мэс заслын тусламжийн тасгийн жижүүр эмчийн үүрэг хариуцлага:

- Яаралтай мэс засал шаардлагатай эмчлүүлэгчийн шинжилгээг бүрдүүлэн тасагт хэвтүүлнэ.
- Мэс засал орох тухай мэдээгүйжүүлгийн эмч болон хамтран орох багт мэдээллэнэ.
- Мэс заслын өмнөх орой эмчлүүлэгчийг амраах ба амарч байгаа эсэхэд хяналт тавина.
- Шаардлагатай тохиолдолд гаднаас мэс заслын эмч хуваарийн дагуу дуудна.
- Шаардлагатай тохиолдолд зөвлөх эмч болон бусад мэргэжлийн эмчийн хамтарсан үзлэг хийж
- Халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан, сувилагч, туслах сувилагч нарт хяналт тавьж ажиллана.
- Эмчлүүлэгчид ЭТҮХХ шинж тэмдгийг тандан шаардлагатай хариу арга хэмжээ авна.
- Жижүүрийн хугацаанд эмчлүүлэгч, түүний гэр бүлийнхэнд эмчилгээ үйлчилгээтэй холбоотой мэдээллийг өгнө.
- Хууль журам заагдсан бусад үүрэг хариуцлага

6.8 ХНТасгийн ахлах сувилагчийн хүлээх үүрэг, хариуцлага:

- Хагалгаа ба мэдээгүйжүүлэг Сувилагч нарын ажил үүрэг, гарган удирдлага зохион байгуулалтаар хангана.
- Сувилахуйн тусламж үйлчилгээг стандартын дагуу гүйцэтгэхэд хяналт тавьж сувилагчийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж аргазүйн зөвлөмж өгнө.
- Мэс заслын өрөөний зохион байгуулалт, бэлэн байдал, үйл ажиллагаа, ХСХ-ын чиглэлээр өдөр тутмын хяналтыг тогтмол хийж зохион байгуулалтаар хангана.
- Мэс заслын тусламжтай холбоотой тайлан мэдээг гаргана.
- Мэс заслын хяналтын хуудсыг /ЭМС-ын тушаалын дагуу/ сар бүр өөрийн гаргасан хуваарийн дагуу хянаж дүгнэлт тайланг Чанарын алба, ХСХА, Сувилахуйн албанд тус тус мэдээлнэ.
- Шаардлагатай тохиолдолд мэс заслын сувилагч, Фильтерийн үүрэг орлон гүйцэтгэнэ.

- Мэс заслын өрөө болон мэс заслын үед хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл тоног төхөөрөмжийн нөөцийн бүрдүүлэлт зарцуулалтанд аюулгүй байдалд хяналт тавина.
- Сувилагч нарт ААЗааварчилгааг өглөө бүр өгч баталгаажуулна.
- ХНТасгийн ХСХ-ын ажилтны үүргийг гүйцэтгэнэ.
- Хууль журам заагдсан бусад үүрэг хариуцлага

6.9 Мэдээгүйжүүлгийн сувилагчийн үүрэг, хариуцлага:

- Мэдээгүйжүүлгийн аппарат тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг шалган, хяналтын хуудсыг бүртгэж, мэдээгүйжүүлгийн эмчид бүрэн эсэхийг илтгэнэ.
- Эм тарианы бэлэн байдлыг стандартын дагуу бэлтгэнэ.
- Мэс заслын хүрээ хагалгааны хүлээгдэх хүндрэлээс хамааран найдвартай 2 оос доошгүй судсанд уян зүү байрлуулан бэхлэнэ.
- Хяналтын хуудсыг нэрээр мэдээгүйжүүлгийн сувилагч бүртгэнэ.
- Хяналтын сувилагч байхгүй үед өвчтөнг хүлээн авч, хүлээлгэн өгнө
- Мэдээгүйжүүлгийн сувилагчийн хагалгаанд гүйцэтгэх стандартыг мөрдлөг болгон ажиллана.
- Монитор болон мэдээгүйжүүлэх машины аюулгүй ажиллагааг хянаж, шаардлагатай тохиолдолд инженер дуудна.
- Хэрэглэгдэх эм таианы тун нэршилийг хянана.
- Халдвар хамгааллын дэглэмийг нарийн баримтлана.
- Сэрээх өрөөний сувилагчийг орлон ажиллана.
- Хог хаягдлыг ангилан цуглуулж түр хадгалах цэгт хүргэнэ.
- Мэс заслын дараа аппарат тоног төхөөрөмжийг цэвэрлэж, хүчилтөрөгчийн нээлхийг хаана.
- Анхан шатны бичиг баримтыг хөтлөн баталгаажуулна.

6.10 Мэс заслын сувилагчийн үүрэг, хариуцлага

- Хагалгааны өмнө мэс заслын эмчид тухайн хагалгаанд бэлтгэсэн тусгай багаж төхөөрөмж, дутагдалтай зүйлсийг танилцуулна.
- Мэс засалд хэрэглэгдэх багаж, нарийн төвөгтэй мэс ажилбарын багажуудыг нэмэлтээр бэлтгэсэн байх /уушигны самбар, Т-гуурс, үдэгч аппаратуудыг цэнэглэх, цус тогтоогч губка, хамрын чихээс, гипс, чиг, утас, дурангийн хэрэгслүүд/
- Хагалгаанд хэрэглэгдэх бор материал, цагаан материал болон дахин хэрэглэгдэх зүйлсийг ариутгалын тасгаас авч, бэлтгэсэн байна.
- Гистологи болон бактериологи шинжилгээ авагдах, эмчлүүлэгчийн нэр бүхий сав бэлтгэсэн байна.
- Хагалгаанд хэрэглэсэн багаж материалыг халдваргүйжүүлж, уусмалд хийн битүүмжилж төвлөрсөн ариутгалд хүргэнэ.
- Анхан шатны маягтыг журмын дагуу хар өнгийн арилдаггүй бэхээр татлалгүй хөтөлж, нэрээ овгийн эхний үсэгтэй гаргацтай бүтэн бичнэ.
- Хагалгаанд орсон өвчтөний бүртгэл хөтлөж, /журнал/ хадгална.
- Мэс заслын дараах өрөөний цэвэрлэгээ халдваргүйтгэл агааржуулалтанд хяналт тавин бэлэн байдлыг хангуулна.

- Эмчийн зааврын дагуу гистологийн эдийг шалгаж, тусгай зориулалтын саванд хийж, өвчтөний овог нэр, нас, тасгийн нэрийг савны гадна нааж дагавар бичгийг эмчээр бичүүлэн авна.
- Хагалгаанд хэрэглэсэн материалын зарлагын хуудсыг бүртгэж, туслах эмчээр гарын үсэг зуруулна.
- Туслах сувилагч болон үйлчлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавина.
- Мэс заслын сувилагчийн хяналтын хуудсыг бүрэн хөтлөж баталгаажуулна.

6.11 Хагалгааны туслах сувилагчийн үүрэг хариуцлага

- Эмчлүүлэгчийг байрлуулна.
- Хагалгаанд хэрэглэгдэх уусмалуудыг бэлэн байлгана.
- Цус тогтоогч түлэгч аппаратын идэвхгүй электродын бүрэн бүтэн байдлыг шалгаж, 2-р туслах эмчтэй хамтарч биеийн зохих хэсэгт байрлуулна.
- Багаж халдваргүйжүүлэх уусмал бүхий сав бэлтгэнэ.
- Хог хаягдлын уут, аюулгүйн хайрцгийг бэлэн байрлуулна
- Хагалгаанд хэрэглэгдэх аппарат тоног төхөөрөмжийг хагалгааны явцад залгах, салгах, тохируулах үйлдлийг гүйцэтгэнэ.
- Хэрэглэгдэх уусмалын хаягийг эмч, сувилагчид шалгуулна.
- Хагалгааны үед отсосоор сорсон шингэний талаар ямар төрлийн шингэн хэдэн мл, литр гарсаныг оператор эмчид мэдээлж байна.
- Эмчлүүлэгчийг орон дээр туслах эмч, мэдээгүйжүүлгийн багийнхантай хамт зөв байрлуулж, биеийн дарагдах хэсгийг хамгаална.
- Хагалгааны үед сувилагчид шаардлагатай нэмэлтээр хэрэглэгдэх багаж, материал, эм тариа, шингэнг авч өгнө.
- Хагалгааны явц дунд хэрэглэсэн шарик, салфеткийг цуглуулж, хагалгааны сувилагч тоолж бүртгэсний дараа зориулалтын саванд хийнэ.
- Хагалгаа дууссаны дараа идэвхгүй электродыг үйлчлүүлэгчийн биенээс салгаж авахад арьс гадаргуу бүрэн бүтэн эсэхийг нэгдүгээр туслах эмчид мэдээлнэ.
- Цус, биеийн шингэн болсон эмнэлгийн хэрэгсэл тоног төхөөрөмжийн гадаргууг халдваргүйтгэлийн бодис бүхий алчуураар арчиж цэвэрлэнэ
- Хувцас солих өрөөг цэгцэлж, хэрэглэгдсэн хувцаснуудыг тоолж, зориулалтын уутанд хийж, угаалганд хүлээлгэн өгч буцаан авна.
- Бохирдсон багаж хэрэгслийг шууд халдваргүйтгэлийн уусмалд хийнэ.
- Хог хаягдлыг зориулалтын уут болон аюулгүй хайрцагт хийж битүүмжлэн хаяг тавьж, устгалд шилжүүлнэ.
- Хагалгааны ор, хормогч халдваргүйтгэлийн уусмалаар арчиж цэвэрлэнэ.
- Хагалгааны дараах цэвэрлэгээг чанартай хийнэ.
- Өмссөн табчикнуудыг халдваргүйжүүлэх уусмалаар угаана.
- Үйлчлүүлэгчийн ажилд хяналт тавина.
- Фильтер сувилагчгүй үед үүргийг орлон гүйцэтгэж болно.

6.12 Хяналтын /Фильтер/ сувилагчийн үйл ажиллагаа

- Мэс засалд өмсөх зориулалтын хувцасны иж бүрдлийг шаардлагатай хэмжээгээр бэлтгэнэ.
- Хагалгааны блокруу орох ажилчдын хувцаслалтанд хяналт тавина.
- Тасгаас ирсэн эмчлүүлэгчийг өвчний түүхийн хамт овог нэр, ямар хагалгаа хийлгэх талаар тодорхой нягтлан зөв танин хүлээн авч бүртгэлд бүртгэнэ. Хэрэв хяналтын сувилагч байхгүй тохиолдолд мэдээгүйжүүлгийн сувилагч, хагалгааны ахлах сувилагч, туслах сувилагч, хагалгааны сувилагч нар орлон үүрэг гүйцэтгэх бөгөөд Хяналтын сувилагчаар тухайн өдөр хүн ажиллахыг ХНТ эрхлэгч үүрэгжүүлсэн байна. Мэргэжил дурьдагдсан суилагч нар хяналтын сувилагчийн ажил үүрэгт суралцсан байна.
- Эмчлүүлэгчийн танин тодруулах асуулгыг өөрөөс нь сонсогдохоор асууж магадлан, бугуйвч түүхэнд бичигдсэн мэдээлэлтэй тулган хагалгааны төлөвлөгөөнд тэмдэглэснийдагуу мэс засал, унтуулгын эмч болон сувилагчид хүлээлгэн өгнө.
- Хагалгааны төлөвлөгөөнд эмчлүүлэгч, хагалгааны багийн орсон, гарсан цагийг тэмдэглэж, хагалгаа ороогүй хойшлогдсон, нэмж орсон хагалгаануудыг шалтгаан зэрэг өөрчлөлтийг тодорхой бичнэ.
- Ажилчдаас бусад хүмүүсийн зөвшөөрлийн бичгийг шалгаж оруулна. ХНТасаг мэс заслын өрөөнд нэвтрэх зөвшөөрлийг ЭЭДЗ,ЧАБАД,ХНТ эрхэлгч өгнө. Зөвшөөрөлгүй тохиолдолд оруулахгүй бөгөөд холбогдох албан тушаалтанд мэдэгдэнэ.
 - Эмчлүүлэгчийн шинжилгээг хянаж, элэгний ДОХ, ХДХВ, тэмбүү, В, С вирус зэрэг тохиолдолд анхааруулах бичгийг хагалгааны өрөөний үүдэнд тэмдэглэнэ.

6.13 Сэрээх өрөөний сувилагчийн хүлээх үүрэг, хариуцлага:

- Хагалгаанаас гарч ирсэн эмчлүүлэгчийг мэдээгүйжүүлгийн картны хамт хүлээж авна.
- Сэрээх өрөөнд орсон цаг минут тэмдэглэнэ. Сэрээх өрөөний бүртгэлийн журналд амин үзүүлэлтүүдийг тэмдэглэнэ эмчээр баталгаажуулна. Мэдээгүйжүүлгийн картны шилжсэн цаг минутыг тэмдэглэнэ.
- Бүрэн сэрсний дараа эмчлүүлэгчийг мэдээгүйжүүлгийн картны хамт тухайн тасгийн сувилагчид хүлээлгэн өгнө.
- Цус,цусан бүтээгдэхүүний протоколыг стандартын дагуу сувилагч хөтлөн, эмчлэгч эмч болон жижүүрийн эмч хянан баталгаажуулан баримжуулна. Цус, цусан бүтээгдэхүүн хийж дуусаагүй бол тасаг руу шилжүүлэхдээ тасгийн сувилагчид хүлээлгэж өгөх.
- Эмчлүүлэгч болон түүний ар гэрийхэн, асран хамаалагч нартай эелдэг найрсаг харилцана.
- Шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлын хангалтыг хянаж, шаардлагатай үед захиалга хийх Эмнэлгийн тусгай хог хаягдлыг стандартын дагуу ангилан, устгаж баталгаажуулна.
- Тухайн өдрийн сэрээх өрөөний сувилагчаар ажиллах сувилагчийг ХНТ эрхлэгч нь мэдээгүйжүүлэг сувилагч нараас томилж үүрэгжүүлнэ.

6.14 Үйлчлэгчийн үүрэг, хариуцлага:

- Хагалгаа эхлэхээс 30 минутын өмнө халдваргүйтгэлийн бодис бүхий чийгтэй цэвэрлэгээ хийнэ.
- Хагалгааны явц дунд цус, биеийн шингэн болсон шал, гадаргууг халдваргүйтгэлийн бодис бүхий алчуураар арчиж цэвэрлэнэ.
- Эмч, сувилагч нарын удирдлагаар шаардлагатай ажлыг гүйцэтгэнэ.
- Хагалгааны явцын цэвэрлэгээг чанартай хийнэ.
- Туслах сувилагч байхгүй тохиолдолд түүний үүргийг гүйцэтгэнэ

6.15 Мэс заслын тусламж бүхий тасгийн сувилагчийн хүлээх үүрэг, хариуцлага:

- Сувилахуйн тусламж, үйлчилгээг холбогдох журам стандартын дагуу чанартай шуурхай үзүүлнэ.
- Эмчлүүлэгчийг бие болоод сэтгэлзүйг мэс засалд бэлтгэнэ.
- Эмчлүүлэгчийн амрааж хонох ба сайн амарч байгаа эсхэд хяналт тавина.
- Мэс заслын эмч, мэдээгүйжүүлэгч эмчийн заавар зөвлөгөөг бүрэн биелүүлнэ.
- Цэвэрлэх клизм, хоол сойх, үс хусах, хүүхэн хараа өргөсгөх, тайван амраах, унтуулах гэх мэтийн үйл ажиллагааг эмчийн зааврын дагуу гүйцэтгэнэ.
- Мэс заслын хэсэгрүү эмчлүүлэгчийг бэлтгэн зөөнө.
- Эмчлүүлэгийн хувцас хөнжил гэх мэт эд зүйлсийг мэс заслын хэсэгрүү зөөвөрлөнө.
- Сэрээх өрөөнөөс эмчлүүлэгчийг тасагтаа хүлээн авна.
- Эмчийн зааврын дагуу мэс заслын дараах хяналт, эмчилгээ үйлчилгээг цаг алдалгүй гүйцэтгэнэ.
- Эмчлүүлэгчийг сонсож зовуурь шаналгааг эмчлэгч эмч болон жижүүр эмчид мэдээлж баталгаажуулна.

6.16 Мэс заслын тусламж бүхий амбулаторийн эмчийн үүрэг, хариуцлага

- Эмчлүүлэгчид бүтэн биеийн үзлэг хийж мэс заслын эмчилгээг шаардлагатай эсэх заалтыг гаргана.
- Мэс засалд орох эмчлүүлэгчийн шинжилгээг бүрэн бүрдүүлж, мэдээгүйжүүлгийн эмчид үзүүлнэ.
- Хэвтэх бичиг үйлдэж тасгийн эрхлэгчид илгээх
- Шаардлагатай тохиолдолд эмчлүүлэгчийг амбулатороор зөвлөх эмчид үзүүлж оношилгоо эмчилгээний асуудлыг шийдвэрлэнэ.
- Халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагааг баримтлан ажиллана.
- Амбулатороор жижиг мэс ажилбар хийж байгаа тохиолдолд амбулаторт хийгдэх мэс ажилбарын хуудас хөтөлж гарын үсгээр баталгаажуулна.
- Амбулаторийн сувилагчийн үйл ажиллагаанд хяналт тавина.
- Бусад үйл ажиллагаа

6.17 Инженер техникчийн үүрэг, хариуцлага:

- Ажлын өдрүүдэд өглөө бүр мэс заслын өрөөнд багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж аюулгүй ажиллагааны зааварчилгааг мэс заслын сувилагч туслах сувилагч нарт өгнө.
- Мэс заслын өрөөний багаж тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцан эвдэрсэн доголдсон тохиолдолд хугацаа алдалгүй хэвийн үйл ажиллагаанд оруулах
- Хүчилтөрөгчийн хангамжийн бэлэн байдал хангалтанд байнгын хяналт тавих

- Техникийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг аппаратны хажууд бүрэн байрлуулах ба эмч сувилагч нарт аппаратыг ажлуулах сургалт мээдллийг тогтмол хийнэ.
- Хагалгааны өмнө аппаратуудын бүрэн бүтэн байдлыг шалгаж, аюулгүй байдлын талаар эмч, сувилагч нарт танилцуулж гарын үсэг зуруулсан байна.
- Инженер техникч нар өглөө бүр мэс заслын өрөөнд орж багаж тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг үнэлэж хагалгааны нэгдсэн тасгийн сувилахуйн арга зүйчид танилцуулсан байна.
- Хийгдсэн засвар үйлчилгээний талаар тусгай дэвтэрт тэмдэглэл хөтөлнө.
- Багаж, тоног төхөөрөмжийн эвдэрлийг засварлаагүй тохиолдолд холбогдох хүмүүст яаралтай мэдэгдэнэ.

ДОЛОО. БОЭТ-Д ХИЙГДЭХ МЭС ЗАСЛЫН ЖАГСААЛТ

1. Ерөнхий мэс заслын чиглэлээр хийгдэх мэс засал

- Дурангаар цөсний хүүдий авах
- Нээлттэй цөсний хүүдий авах
- Цөсний ерөнхий цоргын чулууг нээлттэй авах
- Ходоодны шарх өөлж авах
- Гэдэсний түгжрэл /хүүхэд, том хүн/ түүний хүндрэл засах
- Хэвлий цавины бүх ивэрхий
- Мухар олгой авах, түүний хүндрэлийг засах /нээлттэй ба дурангаар/
- Төмсөг буулгах
- Төмсөгний өргөссөн венийн судас боож тайрах
- Өөхөн ур гигром, аторома авах
- Шамбарам тайрч авах
- Хошног шулуун гэдэсний цорго буглаа нээх
- Төмсөг авах төмсөгний буглаа нээх
- Яаралтай хавдрын мэс засал
- Жижиг мэс ажилбар
- Хошногны цууралт авах
- Давсагний нээлттэй аргаар чулуу авах ,давсагний ур авах
- Нээлттэй аргаар давсагний эдийн шинжилгээ авах
- Бөөрний хавдар уйланхай авах мэс засал
- Нээлттэй болон дурангийн аргаар түрүү булчирхай авах, тайрах
- Бөөрний чулуу нээлттэй авах
- Шээлгүүрийн чулуу авах
- Давсагны чулуу авах
- Цистостом
- Нифростом
- Шээлгүүрт стент тавих
- Элэгний хавдар, үүсгэвэр бэтэг авах тайрах
- Ходоодны хавдар тайрах
- Бүдүүн шулуун гэдэсний хавдар авах
- Ивэрхийг дурангаар засах /цавь ,өрц/
- Цөсний замыг гэдэстэй залгах мэс ажилбар
- Мухар олгой дурангийн аргаар авах
- Цээжний хөндийн мэс засал
- Судасны мэс засал//Флебэктомия/

2. Гэмтлийн чиглэлээр хийгдэх мэс засал

- Гавал ясны цөмөрсөн хугарал
- Гэмтлийн гаралтай тархины цусан хураа
- Тархины цус харвалтын дараах
- Гавал ясны шарх цэгцлэх
- Эгэмний хугарал
- Хавирганы хугарал
- Цээж хэвлийн гэмтлийн шалгаант дотор эрхтнүүдийн хагалгаа
- Шууны хугарал
- Атгаалны хугарал
- Сарвууны хугарал
- Үхжсэн арьс авах ба нөхөх
- Дээд болон доод мөчдийн тайралт
- Түнхний үе солих
- Өвдөгний үе солих
- Дунд чөмөгний хугарал
- Шилбэний хугарал
- Тавхайны гэмтэл
- Шивнүүр ясны хугарал
- Шагайн хугарал
- Шөрмөс залгах
- Мөчдийн судас залгах
- Мэдрэл чөлөөлөх

3. Чих хамар хоолойн чиглэлээр хийгдэх мэс засал

- Хамрын таславч тэгшлэх мэс засал
- Хамрын самалдаг тайрах, түлэх мэс засал
- Гадна хамрын хуучин хугарал засах мэс засал
- Хамар дайвар хөндийн дурангийн мэс засал
- Чихний хэнгэрэг нөхөх мэс засал
- Дунд чихний хөндийг цэвэрлэх, чихний хэнгэрэг нөхөх мэс засал
- Тагнайн гүйлсэн булчирхайг авах мэс засал
- Тагнайн гүйлсэн булчирхайг нармайн гүйлсэн булчирхайтай хамт авах мэс засал
- Чих хамар хоолойн байрлалтай мэнгэ, ургацаг, үү авах мэс засал
- Гадна чихний төрөлхийн уутанцар авах мэс засал
- Залгиур тагнайн гүйлсэн булчирхай орчмын буглаа нээх мэс засал
- Трахеостомын гуурс тавих мэс ажилбар
- Хэнгэргэн хальсанд гуурс тавих мэс засал
- Чих хамар хоолойн байрлалтай хатиг буглаа нээх мэс засал
- Бусад жижиг мэс ажилбарууд

4. Эрүү нүүрний мэс заслын чиглэлээр хийгдэх мэс засал

- Эрүү яс хадах
- Шанаа яс хадах
- Ухархайн яс хадах
- Хацар яс хадах
- Хоншоор яс хадах
- Хэлний хөвч уртасгах
- Уруулын хөвч уртасгах
- Саатсан болон хүндрэлтэй шүдийг мэс заслынаргаар авах
- Илүү шүдийг мэс заслынаргаар авах

- Ялтас авах
 - Зөөлөн эдийн уйланхай авах
 - Эрүүн доорх шүлсний булчирхай хоргүй хавдарыг булчирхайтай нь хамт авах
 - Зөөлөн эдийн хоргүй хавдар авах /атером липома мэнгэ/
 - Нээлттэй биопси
 - Шарх цэгцлэх
 - Нөхөн сэргээх мэс засал /далбан үүсгэх аргаар/
 - Ясны уйланхай авах
 - Сурвалжийн орой тайрах
 - Ясны хоргүй хавдар авах
 - Хоншоор хөндийд Caldwell- lukмэс засал
 - Секвестрэктоми
 - Буглаа хатиг нээх
 - Ясны хальсны буглаа нээх
 - Нэвчээс нээх
 - Буйл тайрах
 - Яс нөхөх
 - Буйланд саатсан шүдний буйланд цонх гаргах
 - Шарханд цэгцлэлт хийх
 - Бамбай булчирхайг авах хэсэгжлэн тайрах
 - Толгой хүзүүний мэс заслын бусад тусламж
- 5. Нүдний чиглэлээр хийгдэх мэс засал**
- Болрын мэс засал
 - Нүдний даралтны мэс засал
 - Нүдний мах, өөх авах
 - Нүдний нэвт гэмтлүүд
 - Зовхины мэс засалууд
 - Мэнгэ , үү , ургацаг авах
 - Сормуусны буруу ургалт засах
 - Хяларын мэс засал
 - Птоз / зовхины буулт засах /
 - Уян болор суулгах
 - Эвэрлэг хусах
 - Бусад жижиг мэс ажилбарууд
- 6. Эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр хийгдэх мэс засал**
- Кесар мэс засал
 - Умайг дайвартай дайваргүй авах тайрах / хэвлий, үтрээ , дурангаар /
 - Үр дамжуулах хоолой авах тайрах боох сэтгүүрдэх
 - Өндгөвч авах тайрах түлэх
 - Умайн гадуурхи жирэмсний үеийн мэс засал
 - Өндгөвчний эмгэгийн үеийн мэс засал
 - Умайд хийгдэх мэс засал
 - Үтрээнд хийгдэх мэс засал
 - Хярзанд хийгдэх мэс засал
 - ТОТ

НАЙМ. МЭС ЗАСЛЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

8.1 Төлөвлөгөөт мэс засалд эмчлүүлэгчийг бэлтгэх, мэс засал хийх

8.1.1 Эмчлүүлэгчийг амбулатороор бүрэн үзлэг хийж мэс засал эмчилгээ шаардлагатай эсэхийг дүгнэн эмчлүүлэгчтэй зөвшилцөн мэс заслын холбогдох бэлтгэлийг төлөвлөж шинжилгээг илгээж, шаардлагатй эмчийн үзлэгийн дугаарыг олгоно.

8.1.2 Ерөнхий мэдээгүйжүүлэгтэй мэс заслын үед дараах шинжилгээг заавал бүрдүүлнэ.

Үүнд:

- Цусны ерөнхий шинжилгээ
- Шээсний ерөнхий шинжилгээ
- Биохимийн шинжилгээ / алат, асат, сахар, креатинин, мочеви́н \
- В, С вирусын маркер
- ХДХВ, Тэмбүү
- Цээжний рентген, ЭХО, КТГ, MRI заалтаар
- Зүрхний цахилгаан бичлэг
- Коагулаграмм
- Цусны бүлэг тодорхойлох
- Мэдээгүйжүүлгийн эмчид амбулатороор үзүүлэх
- Бусад шаардлагатай онцлог шинжилгээнүүд

8.1.3 Хэсгийн мэдээ алдуулалттай мэс заслын үед дараах шинжилгээг заавал бүрдүүлнэ

Үүнд:

- Цусны ерөнхий шинжилгээ
- Шээсний ерөнхий шинжилгээ
- Биохимийн шинжилгээ / алат, асат, сахар, креатинин, мочеви́н
- В, С вирусын маркер
- Зүрхний цахилгаан бичлэг
- ХДХВ, Тэмбүү
- Коагулаграмм
- Цусны бүлэг тодорхойлох
- Бусад шаардлагатай онцлог шинжилгээнүүд тухайлбал Умайн мэс засалд орох эмчлүүлэгчийн умайн хүзүүний эд эсийн шинжилгээ гэх мэт /

8.1.4 Амбулаторийн эмч эмчлүүлэгчийн Шинжилгээний бүрдлийг хянан дүгнэж мэдээгүйжүүлгийн эмчид илгээнэ.

8.1.5 Амбулаторийн мэдээгүйжүүлгийн эмч эмчлүүлэгчийн биед бүрэн үзлэг хийн мэдээгүйжүүлгийн эрсдлийг тооцон мэдээгүйжүүлэг хийх эсэх , мэдээгүйжүүлгийн хэлбэрийг тогтоон мэс засалд орох өдрийг төлөвлөнө.

8.1.6 Амбулаторийн эмч хэвтэх бичиг хийж тасгийн эрхлэгчид илгээнэ

8.1.7 Тасгийн эрхлэгч нь эмчлүүлэгчийн биеийн байдал ,шинжилгээний үзүүлэлтийг харгалзан эмчлэгч эмчийг томилж хэвтэх бичиг цохолт хийнэ.

8.1.8 Тасагт хэвтсэн эмчлүүлэгчийн өвчний түүхийг эмчлэгч эмч нээж, тасгийн эрхлэгчид танилцуулж, хагалгааны төлөвлөгөөнд оруулна.

- 8.1.9 Эмчлэгч эмч мэс засалд орох гэж байгаа үйлчлүүлэгчийн өвчний түүхийн бүрдэлд анхаарал тавьж тасгийн эрхлэгчээр өвчний түүхэнд цохолт хийлгэнэ. ЭМС 2019.12.30 A\611 тоот СТ1 хавсралт 6-ийн дагуу
- Мэс заслын зөвшөөрлийн хуудас
 - Мэс заслын өмнөх дүгнэлт
 - Мэс заслын тэмдэглэл
- 8.1.10 Эмчлүүлэгчийн биеийн байдал мэс заслын хүндрэл зэргийг харгалзан шаардлагатай тохиолдолд клиникийн эрхлэгч, зөвлөх эмч нар мэс заслын эмч нарын багийг сонгож, хамтарсан үзлэг хийж хагалгааны төлөвлөгөөг гаргаж болно.
- 8.1.11 Хагалгаанд орох шаардлагатай бүх асуудлыг эмчлэгч эмч, туслах эмч/мэс засалчдын баг/ хариуцан бэлдсэн байна.
- 8.1.12 Эмчлэгч эмч эмчлүүлэгчид хагалгаа хийгдэх шийдвэр гарсан цагаас хагалгаанд орох цаг хүртэл нь өвчний байдал, холбогдох шинжилгээтэй танилцан, мэс заслын тал, хүрц, эрсдэл, хүндрэлийг эмчлүүлэгч болон ар гэрт нь танилцуулна. Мэс засалд орох эмчлүүлэгчээс болон, эмчлүүлэгч өөрөө зөвшөөрөл өгөх боломжгүй бол ар гэрээс нь зөвшөөрөл авч, гарын үсэг зуруулж, өвчний түүхэнд хавсаргана.
- 8.1.13 Ерөнхий мэдээгүйжүүлэгтэй мэс засалд орох эмчлүүлэгчийг эрчимт мэдээгүйжүүлэгч эмч үзэж, хагалгаанд орох бэлтгэл, заалтыг өвчний түүхэнд бичнэ.
- 8.1.14 Тасгийн ээлжийн сувилагч мэс засалдорох бэлтгэлийг хийнэ.
- 8.1.15 Мэдээгүйжүүлэгч эмч мэдээгүйжүүлгийн хуудсыг бичиж, хагалгаанд бэлтгэх явцад онцгой анхаарах зүйл байвал мэс заслын эмчлэгч эмчид мэдээлнэ.
- 8.1.16 Хагалгааны эрсдлийн зэрэг өндөр, мэдээгүйжүүлэг хийхэд хүндрэлтэй эмчлүүлэгчийн биеийн байдлын талаар дүгнэлт бичиж, эрчимт эмчилгээний клиникийн эрхлэгч, зөвлөх эмчид танилцуулж, шийдвэрлүүлсэн байна.
- 8.2 Эмчлүүлэгчийг яаралтай мэс засалд оруулах.**
- 8.2.1 Үйлчлүүлэгчийг хүлээн авах хэсгийн жижүүр эмч, мэс заслын жижүүр эмч бүтэн биеийн үзлэг хийж, шаардлагатай шинжилгээг бүрдүүлж онош батлан шийдвэр гаргана.
- 8.2.2 Яаралтай мэс засал хийлгэх өвчтөний шинжилгээг мэс заслын эмч төлөвлөж хүлээн авахын сувилагч авна.
- 8.2.3 Яаралтай ерөнхий мэдээ алдуулалттай мэс засалд орох үед хийх шинжилгээ
- Цусны ерөнхий шинжилгээ
 - Биохимийн шинжилгээ / алат, асат, сахар, креатинин, мочевины
 - В, С вирусын маркер
 - ДОХ, ТРНА
 - Цээжний рентгэн
 - Зүрхний цахилгаан бичлэг
 - Коагулаграмм
 - Цусны бүлэг тодорхойлох
 - Бусад шаардлагатай онцлог шинжилгээнүүд
- 8.2.4 Хэсгийн мэдээ алдуулалттай мэс засалд орох үед заавал бүрдүүлэх шинжилгээ

- Цусны ерөнхий шинжилгээ
 - Биохимийн шинжилгээ / алат, асат, сахар, креатинин, мочеви́н\
 - В, С вирусын маркер
 - Зүрхний цахилгаан бичлэг
 - ХДХВ, Тэмбүү ЭХО, КТГ, MRI
 - Цусны бүлэг тодорхойлох
 - Бусад шаардлагатай онцлог шинжилгээнүүд
- 8.2.5 Онош эргэлзээтэй бусад нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлагатай тохиолдолд яаралтай журмаар бусад нарийн мэргэжлийн эмчид үзүүлж дэлгэрэнгүй оношилгоо шинжилгээ хийнэ.
- 8.2.6 Шаардлагатай тохиолдолд ажлын бус цагаар жижүүрийн ахлах эмчийн зөвшөөрлөөр үзлэг, оношлогооны эмч дуудаж хамтарсан үзлэг хийж оношилгоо эмчилгээний асуудлыг шийдвэрлүүлнэ.
- 8.2.7 Яаралтай журмаар онош тодорхой эмчлүүлэгчийг хэвтсэнээс хойш 2-4 цагийн дотор мэс заслын эмчилгээнд оруулна.
- 8.2.8 Яаралтай мэс засал хийлгэх өвчтөн олон байгаа тохиолдолд мэс заслын эмч, эмчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ хийж, эрэмбэлэн оруулна.
- 8.2.9 Эмчлүүлэгчийн биеийн байдал хүнд, онош тодорхойгүй тохиолдолд жижүүр эмч нарын хамтарсан үзлэг, зөвлөх эмч, тасгийн эрхлэгчид үзүүлж, хамтарсан шийдвэр гаргана. Ажлын бус цагаар утас цахимаар зөвлөгөө авч болно.
- 8.2.10 Яаралтай хагалгаанууд зэрэг орох шаардлага зайлшгүй гарвал мэс заслын жижүүрийн эмч жижүүрийн ахлах эмчтэй зөвшилдсөнөөр мэдээгүйжүүлэгч болон хагалгааны сувилагчийг нэмэлтээр дуудаж болно.

8.3 Мэс засал эмчилгээ хийлгэх гэж байгаа үйлчлүүлэгчийг мэс заслын өмнөх өдөр бэлтгэх

- 8.3.1 Эмнэлэгт хэвтээгүй тохиолдолд өвчний түүхийг нээж орох мэс заслын нэр төрөл ач холбогдол, хүрц, эдгэрэл сайжрал, эрсдэл хүндрэлийн талаар эмчлүүлэгч болон түүний ар гэрийнхэнд тайлбарлан өгч мэс заслын зөвшөөрөл авна.
- 8.3.2 Мөн эмчлэгч эмч тухайн өдөр баримтлах дэглэм, өөрийгөө мэс засалд бэлтгэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл эмчлүүлэгчид өгнө.
- 8.3.3 Мэдээгүйжүүлгийн эмч эмчлүүлэгчийг үзэж биеийн байдлыг үнэлэн мэдээгүйжүүлгийн явцад гарч болзошгүй эрсдэлт хүчин зүйлсийг тайлбарлан урьдчилан сэргийлж бэлтгэх зүйлсийг танилцуулна.
- 8.3.4 Тухайн тасгийн ээлжийн сувилагч, жижүүр эмч эмчлүүлэгийн бие болоод сэтгэлзүйн бэлтгэлийг эмчлэгч эмч, мэдээгүйжүүлгийн эмчийн заавраар сайтар хийнэ.
- Шаардлагатай тохиолдолд цэвэрлэх клизм тавих, мэс заслын талбайг бэлтгэх
 - Хоол сойх
 - Мэс заслын хэсэгрүү орохдоо өмсөх хувцасны төрөл зөвлөх
 - Сэтгэлзүйг тогтворжуулах
 - Зөвлөгөө өгөх
 - Унтаж амраах
 - Бусад онцлог зүйлсийн бэлтгэлийг хангана. Жишээ нь хүүхэн хараа өргөсгөх, хэл дарах дасгал хийлгэх гэх мэт
- 8.3.5 Мэс засал эмчилгээ хийлгэх гэж байгаа үйлчлүүлэгч мэс заслын өмнөх өдөр биеийн байдал хямарч зовуурь шаналгаатай байгаа тохиолдолд тухайн

өдрийн жижүүр эмчийн заавар хяналтанд эмчилгээ, хамтарсан үзлэг, зөвлөгөөн хийж асуудлыг шийдвэрлэнэ.

Ёс . Хагалгааны төлөвлөгөө боловсруулж, баталгаажуулах

- 9.1 Хагалгааны төлөвлөгөөг тасгийнхаа орны ачаалал, хүлээгдэл, хагалгааны эрсдэл , өдрийн ажлын цаг болон долоо хоногийн ажлын өдөр зэргийг харгалзан үзэж, хагалгааны нэгдсэн тасгийн эрхлэгч хариуцан төлөвлөнө.
- 9.2 Мэс заслын төлөвлөгөөг мягмар гаригт лхагва гаригт орох мэс заслын төлөвлөгөө, лхагва гаригт пүрэв гаригт мэс засалд орох төлөвлөгөө , баасан гаригт даваа гаригт мэс засалд орох төлөвлөгөөг тус тус гаргана.
- 9.3 Төлөвлөгөөнд оруулж байгаа үйлчлүүлэгчийн үзлэг шинжилгээг гүйцэт бүрдүүлсэн байна
- 9.4 Эмчлэгч эмч хагалгааны төлөвлөгөөг хагалгааны төлөвлөгөө гаргах өдрийн 17 цагаас өмнө өгөх ба төлөвлөгөөнд эмчлүүлэгчийн овог нэр , нас, хүйс, онош, хийгдэх хагалгаа, багийн эмч нарын нэр, мэдээгүйжүүлгийн төрөл зэргийг алдаагүй үнэн зөв бичиж, хагалгааны нэгдсэн тасгийн эрхлэгчид өгнө.
- 9.5 Хагалгааны нэгдсэн тасгийн эрхлэгч, сувилахуйн арга зүйч нар төлөвлөгөөг мэс засал орох өрөө, цагийн хуваарийг дэлгэрэнгүй хийж ЭЭДЗ захирлаар батлуулан мэс засалтай тасаг бүрт нэг хувийг өгнө.
- 9.6 Мэс засалд орох багийн бүрэлдэхүүний өөрчлөлтийг тасаг клиникийн эрхлэгч хариуцна.
- 9.7 Төлөвлөгөөт мэс засал хойшлогдсон тохиолдолд төлөвлөгөөнд байгаагүй яаралтайгаас бусад эмчлүүлэгчийг дур мэдэн оруулахгүй.
- 9.8 Төлөвлөгөөт хагалгаа явагдаж байгаа үед яаралтай хагалгаа орох тохиолдолд хагалгааны нэгдсэн тасгийн тасгийн эрхлэгч эмч, мэдээгүйжүүлэгч эмч, ахлах сувилагч нар хагалгааны өрөөний зохицуулалт хийнэ.
- 9.9 Төлөвлөгөөт хагалгаа явагдаж байгаа үед яаралтай хагалгаа орох тохиолдолд хагалгааны өрөөний зохицуулалт хийгдэж, тухайн өрөөнд ажиллаж буй мэдээгүйжүүлгийн эмч, сувилагч, хагалгааны сувилагч нар тухайн мэс засалд орно.
- 9.10 Ажлын цагаар яаралтай мэс засал ороход хяналтын сувилагч яаралтай мэс заслын дэвтэрт бүртгэн мэс заслын өрөөнд оруулна.
- 9.11 Долоо хоногийн хагалгааны тайланг хагалгааны ахлах сувилагч нэгтгэж, 2 дахь өдөр бүрийн тасгийн ярианд мэдээлэл хийнэ.
- 9.12 Тасгийн эрхлэгч нь хагалгааны төлөвлөгөөний хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж, тулгамдсан асуудал гарвал тухай бүр шийдвэрлэх ба боломжгүй асуудлыг хариуцсан удирдах хүмүүст мэдэгдэнэ.
- 9.13 Төлөвлөгөөнд ороогүй боловч мэс засалд орох зайлшгүй шаардлагатай тохиолдол гарвал ЭЭДЗ, ТЭ, нар хамтарсан зөвлөгөөний шийдвэрээр оруулна.
- 9.14 Урьд өдөр нь төлөвлөгдөөд мэс заслын өрөөний хүрэлцээнээс шалтгаалан хойшлогдсон хагалгааг дараа өдрийн төлөвлөгөөнд оруулна.
- 9.15 Өдрийн мэс ажилбар, мэс заслыг өдрийн эмчилгээний түүх нээн, жижиг мэс ажилбарыг “Амбулаторийн мэс заслын хуудас”-г бүрэн хөтөлж болно.
- 9.16 Мэс заслын төлөвлөгөөнд мэс засал эхлэх цагийг дэс дараалалтайгаар бичих ба мэс заслын өрөөнд цагаа баримтлан үйлчлүүлэгчийг оруулна.
- 9.17 Мэс заслын өрөөнд эхний үйлчлүүлэгч 09:00 цагт оруулсан байна.

Арав. Мэс заслын өрөөнд орохын өмнө мэс заслын багийнхан дараах үйл ажиллагааг хийнэ

- 10.1 Мэс заслын тусламж үйлчилгээний журам” Мэс заслын аюулгүйн хяналтын хуудас хэрэгжүүлэх “ зааварчилгаатай танилцсан байна.

- 10.2 Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны болон технологийн зааварчилгаатай танилцаж, судалж мэдсэн байна.
- 10.3 Хагалгаанд орж байгаа багийн гишүүд хагалгааны төлөвлөгөөтэй танилцаж, хийгдэх мэс заслын талаар бүрэн ойлгоцтой болсон байна.
- 10.4 Эмч, ажилчид зориулалтын өмд, цамц, углааш, малгай, маск сольж өмсөх бөгөөд хагалгааны хэсгийн хяналтын сувилагчийн шаардлагыг биелүүлж, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлана.
- 10.5 Мэс заслын болон мэдээгүйжүүлгийн эмч нар зөвшөөрөлгүйгээр гадны хүмүүс дагуулж орохыг хориглоно.
- 10.6 Төлөвлөгөөт болон яаралтай хагалгааны багийн гишүүдээс бусад хүмүүс /резидент, мэргэжил олгох болон дээшлүүлэх сургалтанд хамрагдаж буй эмч, сувилагч, туршлага судлах багийнхан/ БОЭТ-ийн Сургалтын алба, ЭЭДЗ даргын зөвшөөрөл авч, урьдчилж зохицуулагдсан байна. Хагалгааны хэсгийн талбай, агааржуулалт, хүний тоог эрүүл ахуйн дүрэм, халдвар хамгааллыг зөрчихгүйгээр тооцно.
- 10.7 Халдвар судлаач эмч, чанарын багийн гишүүд 14 хоногт 1 удаа хяналт тавьж, үзлэг хийнэ.
- 10.8 Аюулгүйн хяналтын хуудсыг мэс заслын болон мэдээгүйжүүлгийн багийнхан зааварчилгааны дагуу хөтөлнө.

Арван нэг . Мэс заслын багийнхны үйл ажиллагаа

11.1 Оператор эмч

11.1.1 Мэс заслын өмнө

- Эмчлүүлэгчийг мэс засалд орохоос өмнө хагалгааны тактикийг боловсруулан тасгийн эрхлэгч, зөвлөх эмчид танилцуулж, туслах эмч нарыг хагалгааны талаар бүрэн мэдлэгтэй болгосон байна. Хагалгаанд орохоос өмнө эмчлэгч эмч хагалгаанд орох багийн гишүүдтэйгээ зөвлөж хагалгаа хийх тал, хийх зүслэгийг арилдаггүй биеийн харандаагаар эмчлүүлэгчийн биеийн хэсэгт тэмдэглэсэн байна. Эмчлүүлэгч өөрөө хүсвэл биен дээрээ эмчийн зааснаар зурж болно.
- Эмчлэгч эмч болон мэс засалд оператороор орох эмч хагалгаанд хэрэглэгдэх нэмэлт багажийг хагалгааны сувилагчид урьдчилан хэлж бэлтгүүлсэн байна.
- Мэс заслын өрөө рүү өвчний түүх болон шаардлагатай зургыг авч орсон байна.
- Хагалгааны үед гарч болох хүндрэлийг тооцож, шаардлагатай /эм тариа, багаж төхөөрөмж, цусны бүлэг тодорхойлох, цус цусан бүтээгдэхүүн г.м/ зүйлсийг урьдчилж шийдүүлж, бэлэн байдлыг хангана.

11.1.2 Мэс заслын үед

- Хагалгаанд орж байгаа мэс заслын багийг удирдаж ажиллах ба нарийн төвөгтэй мэс ажилбарыг өөрөө хийнэ.
- Туслах эмчийн хийж чадах хагалгааг өөрийн хяналтын дор хийлгэж болно.
- Эмчлүүлэгчийг хагалгааны ширээн дээр зөв байрлуулах, ивээс бэхлэгээ аюулгүй зөв хийсэн байдалд хяналт тавьж, шалгана.
- Хагалгаанд хэрэглэгдэх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн /дуран, коагуляци, отсос г.м / байрлуулалт, хэрэглэх нөхцөл, технологийн дагуу ажиллагаанд хяналт тавина.
- Хагалгаа эхлэхээс өмнө хагалгааны багийнхан “Хяналтын хуудас” бүртгэгчид НЭГ минут завсарлан, аман асуумжаар бүртгүүлсний дараа анхаарлаа

төвлөрүүлэн, оператор эмчийн “бэлэнболлоо” гэсэн дохиогоор хагалгааг эхэлнэ. Ерөнхий болон дамжуулах мэдээгүйжүүлэгтэй хагалгаанд орж байгаа тохиолдолд мэдээгүйжүүлгийн эмч хагалгаа эхлэх саналыг оператор эмчид мэдэгдэнэ.

- Хагалгааны үед төлөвлөсөн тактик еөрчлөгдөх, өвчтөн хүндэрсэн тохиолдолд багаараа хэлэлцэж, нэмэлт шинжилгээ /ЭХО, рентген, дуран/ авах, зөвлөх эмчийн зөвөлгөө авах г.м асуудалд шийдвэр гаргана.

11.1.3 Мэс заслын дараа

- Хагалгааны дараах эмчилгээний бүх асуудлыг хариуцна.
- Хагалгааны тэмдэглэлийг өвчний түүхэндбичнэ.
- Хагалгааны дараа эмчлүүлэгч хүнд үедэ рчимт эмчилгээний тасагт шилжүүлэх болон эмчилгээний талаар мэдээгүйжүүлэгч болон тухайн тасгийн эрхлэгчтэйярилцаж шийдвэрлэнэ.
- Эрчимт эмчилгээндорх болсон заалтыг өвчний түүхэнд тусгана.
- Хагалгааны дараа ар гэрийнхэн болон өөрт нь уг өвчний талаар тодорхой зөвөлгөө тайлбар хийнэ.

11.2 Нэгдүгээр туслах эмч

11.2.1 Мэс заслын үед

- Гарыг угаах, халат, бээлийг стандартын дагуу өмсөх бөгөөд бусад ажилчдад хяналт тавина.
- Гараа угаасны дараа хагалгааны талбайг угааж, ариутгана.
- Хагалгааны дэс дарааг мэддэг байна.
- Хагалгаа хийж буй эмч зөвшөөрсөн тохиолдолд мэс ажилбарыг хийнэ.
- Хагалгааны үед цус алдалт болон бусад хүндэрлийн үед санал бодлоо солилцон тодорхой шийдвэр гаргахад туслана.
- Хагалгаа хийсэн хөндийнүүдэд гадны биет үлдээхгүй байх хариуцлагыг хүлээнэ.
- Хагалгааны шархны орчинг цэвэр байлгана.

11.2.2 Мэс заслын дараа

- Мэс заслын дараа эмчлүүлэгчийг оператор эмчийн хамт хянаана.
- Шархны боолт,эдгэрэлтэнд хяналт тавина.

11.3 Хоёрдугаар туслах эмч

11.3.1 Мэс заслын үед

- Гарыг угаах, халад, бээлийг стандартын дагуу өөрөө өмсөнө.
- Эмчлүүлэгчийг хагалгааны орон дээр байрлуулах, түлэгч аппаратны электродыг туслах сувилагчийн хамт байрлуулна.
- Хагалгааны талбайг мэс ажилбар хийх бололцоогоор ханган, чөлөөтэй ил байлгана.
- Хагалгааны талбайг чөлөөлөх явцад бусад эрхтэнг гэмтээхээс болгоомжилно.
- Хагалгааны үед талбай дээр хэрэглэгдэж байгаа угаах, халдваргүйжүүлэх уусмалд хяналт тавина
- Алдаж байгаа цус соруулагдаж шингэний хэмжээ зэрэгт хяналт тавина.
- Хагалгааны үеийн асептикийг бүрэн чанд сахиулна.

- Гуравдугаар туслагчгүй тохиолдолд үүргийг хоёрдугаар туслах эмч гүйцэтгэнэ.
- 11.3.2 Мэс заслын дараа**
- Хагалгаа дууссанаас хойш өвчтөн бүрэн сэргэж, хагалгааны өрөөнөөс тасагт очих үеийн хяналтыг хариуцна.
 - Сэрээх өрөө рүү эмчлүүлэгчийг шилжүүлэхэд тусална.
- 11.4 Гуравдугаар туслах эмч**
- 11.4.1 Мэс заслын үед**
- Хагалгааны өрөөнд эмчлүүлэгч ирэхэд өвчний түүхийг шалгаж, оператор эмчид танилцуулан ,мэдээгүйжүүлгийн эмчид хүлээлгэн өгнө.
 - Эмчлүүлэгчийг хагалгааны орон дээр байрлуулахад туслана.
 - Гарыг угаах, халад, бээлийг стандартын дагуу өөрөө өмсөнө.
 - Оператор эмчийн шийдвэрээр хагалгааны үеийн рентген, ЭХО, дурангийн шинжилгээг хийх нөхцөл боломжийг хангаж өгнө.
- 11.4.2 Мэс заслын дараа**
- Хагалгааны үед авсан “яаралтай” шинжилгээний материалыг холбогдох газарт /бактериологи, эмгэг анатоми г.м/ хүргэж өгч, хариуг авчирна.
 - Оператор эмчийн зөвлөгөөнөөр бусад материалыг онгойлгох, задалж үзэж танилцуулах, эмгэг анатомийн болон бусад шинжилгээнд бланк бөглөж явуулна.
 - Сэрээх өрөө рүү эмчлүүлэгчийг шилжүүлэхэд тусална.
 - Хэрэв хагалгаанд гуравдугаар туслагчгүй бол үүргийг нь хоёрдугаар туслагч хариуцна.
- 11.5 Мэдээгүйжүүлгийн эмч**
- 11.5.1 Мэс заслын өмнө**
- Мэдээгүйжүүлгийн багийнхан эмчлүүлэгчийг хагалгааны орон дээр ая тухтай байрлуулна.
 - Мэдээгүйжүүлгийн эмч суралцагч, сувилагч нарт тухайн хагалгаандхэн ямар үүрэгтэй талаар зааварчилгааг урьдчилан танилцуулсан байна.
 - Мэс засал хийлгэх эмчлүүлэгчийн биеийн байдалтай танилцаж, мэдээгүйжүүлгийн аюулгүй байдалдурьдчилан хяналт хийж, тохирсон мэдээгүйжүүлгийг сонгон, эм тариа, тоног төхөөрөмж, агаар дамжуулах замын хүндрэл болон бөглөрөл, хийжүүлэлтийг шалгасан байна.
 - Ерөнхий мэдээ алдуулалтын үед мэдээгүйжүүлэг бүрэн хийгдсэн эсэхийг дараах аргуудаар шалгана.
 - ✓ Артерийн даралт
 - ✓ Зүрхний цохилтын тоо
 - ✓ Унтуулгын аппаратын амьсгалын үзүүлэлтийн зураглалаар
 - Нугасны мэдээ алдуулалтын үед мэдээгүйжүүлэг бүрэн хийгдсэн эсэхийг дараах аргуудаар шалгана.
 - ✓ Мэдэрхүй
 - ✓ Хөдөлгөөн
 - ✓ Симпатик

- Хэсгийн мэдээ алдуулалтын үед мэдээгүйжүүлэг бүрэн хийгдсэн эсэхийг дараах аргуудаар шалгана.
 - ✓ Мэдэрхүй
- “Хяналтын хуудас” бүртгэсний дараа, хагалгаа эхлэх саналыг оператор эмчид мэдэгдэнэ.

11.5.2 Мэс заслын үед

- Эмчлүүлэгчид төлөвлөсний дагуу мэдээгүйжүүлгийг стандартын дагуу явуулна.
- Эмчлүүлэгчийг өөрийн хяналтгүй орхихгүй байх.
- Мониторын хяналтаар өвчтөний зүрх, судас, амьсгалын үйл ажиллагаа, мэдээгүйжүүлгийн явцыг хянаж ажиллана.
- Сувилагчийн үйл ажиллагааг удирдана.
- Арван минут тутамд мэдээгүйжүүлгийн картанд унтуулгын явц, эрхтэн системийн байдлыг тэмдэглэж байна.
- Мэдээгүйжүүлэг болон хагалгааны холбогдолтой хүндрэл гарвал хагалгааны баг болон зэрэгцээ ажиллаж байгаа мэдээгүйжүүлгийн багийн гишүүдээс дуудаж, зөвшилцөж шийдвэрлэх ба боломжгүй үед удирдлагад танилцуулж дээд шатны эмнэлгийн зөвлөгөө авна.
- Хагалгааны явцад туслах эмч мэдээгүйжүүлэг хийх бол өөрийн хяналтан дор хийлгэнэ.

11.5.3 Мэс заслын дараа

- Эмчлүүлэгчийг хагалгааны дараа сэрээх өрөөнд шилжүүлнэ.
- Эмчлүүлэгийн биеийн байдлыг үнэлэн дараах тохиодолд сэрээх өрөөнд шилжүүлнэ.
 - ✓ Ерөнхий мэдээ алдуулалттай мэс засал бүрийн дараа
 - ✓ Жижүүрийн хугацаанд ЕМА-тай мэс засал орвол хагалгааны өрөөнд эмчлүүлэгчийн амьсгал цус эргэлтийг тогтвортой болсоны дараа тасаг руу шилжүүлнэ.
 - ✓ Нугасны хэсгийн мэдээгүйжүүлгийн хүндрэлтэй болсон тохиолдолд үйлчлүүлэгчийг сэрээх өрөөнд хянана.
- Эмчлүүлэгчид тавих хяналт, эмчилгээг сэрээх өрөөний журмын дагуу гүйцэтгэнэ.
- Эмчлүүлэгчийг бүрэн сэргэсний дараа мэс заслын тасагт шилжүүлнэ.
- Эмчлүүлэгчийг мэс заслын тасагт шилжүүлэх шалгуур үзүүлэлт
 - ✓ Унтуулах эмийн нөлөө бүрэн гараагүй ч дуудхад нүдээ нээнэ.
 - ✓ Толгойгоо 3 секундээс дээш өргөх команд биелүүлнэ.
 - ✓ Артерийн даралт тогтвортой, артерийн даралт ихэсдэг бол даралт бууруулах тариа хийсний дараа АД 100-160мммуб хооронд байх
 - ✓ Зүрхний цохилтын тоо 1 минутанд 80-110 удаа
 - ✓ SpO2 95% дээш нэмэлт хүчилтөрөгчтэй үед
- Эмчлүүлэгчийг эрчимт эмчилгээнд шилжүүлэх тохиолдолд, тасгийн эрхлэгчид мэдэгдэж орны зохицуулалт хийсэн байна.
- Эрчимт эмчилгээнд шилжсэн эмчлүүлэгчийн эмчилгээг мэдээгүйжүүлгийн эмч бичнэ.

- Мэдээгүйжүүлэг хэвийн явагдсан тохиолдолд мэдээгүйжүүлгийн картыг бүрэн бөглөж, өвчний түүхэнд хавсаргана.
- Мэдээгүйжүүлэг болон хагалгаатай холбоотой хүндрэл гарсан үед өвчний түүхэнд авсан арга хэмжээний талаар сайтар бичиж тэмдэглэнэ.

11.6 Мэдээгүйжүүлгийн туслах эмч

11.6.1 Мэс заслын өмнө

- Хагалгаа эхлэхийн өмнө эмчлүүлэгчийг үзсэн байна.
- Тасгийн сувилагчаас эмчлүүлэгчийг хүлээн авч, хагалгааны орон дээр байрлуулна.
- Мэдээгүйжүүлийн эмчийн хяналтан дор ажиллана.

11.6.2 Мэс заслын дараа

- Хагалгаа дууссаны дараа эмчлүүлэгчийг зөөвөрлөхөд тусална.
- Өөрийн биеэр сэрээх өрөө болон тасагт хүргэж өгнө.

11.7 Мэдээгүйжүүлгийн сувилагч

11.7.1 Мэс заслын өмнө

- Унтуулгын болон хяналтын /монитор/ аппарат тоног төхөөрөмжийг ажилтанд урьдчилан үзүүлж, ажиллагааг шалган, аппарат тоног төхөөрөмжтэй холбоотой хяналтын хуудсыг бүртгэж, мэдээгүйжүүлгийн эмчдээ бүрэн эсэхийг мэдээлнэ.
- Эм тарианы бэлэн байдлыг стандартын дагуу бэлтгэсэн байна.
- Найдвартай судас хатгаж, уян гуурсыг судсандбэхэлж, дусал шингэн залгасан байна.
- Хяналтын хуудсыг хагалгааны туслах сувилагчгүй үед мэдээгүйжүүлгийн сувилагч бүртгэнэ.
- Фильтер сувилагч байхгүй үед өвчтөнг хүлээн авч, хүлээлгэн өгнө

11.7.2 Мэс заслын үед

- Мэдээгүйжүүлгийн сувилагчийн хагалгаандгүйцэтгэхстандартыг мөрдлөг болгон ажиллана.
- Монитор болон мэдээгүйжүүлэх машины аюулгүй ажиллагааг хянаж, шаардлагатай тохиолдолд инженер дуудна.
- Хэрэглэж буй эм тарианыхаа хаягийг сайн шалгана.
- Эмчийн удирдлага, заавар зөвөлгөөгөөр ажиллана.
- Халдвар хамгааллын дэглэмийг нарийн баримтлана.

11.7.3 Мэс заслын дараа

- Ерөнхий мэдээ алдуулалттай хагалгааны дараа эмчлүүлэгчийг мэс заслын өрөөнөөс сэрээх өрөөний сувилагчид хүлээлгэн өгнө.
- Сэрээх өрөөний сувилагчид хүлээлгэн өгнө.
- Хэрэглэсэн хог хаягдлыгзориулалтын савандхийнэ.
- Мэс заслын дараа аппарат тоног төхөөрөмжийг цэвэрлэж, хүчилтөрөгч болон вакумны крантыг хаана.
- Анхан шатны бичиг баримтыг хөтөлнө.

11.8 Хагалгааны сувилагчийн үүрэг

11.8.1 Шаардлагатай тохиолодолд нэмэлтээр мэс заслын 2-р сувилагч орно

11.8.2 Мэс заслын сувилагчид мэс засалд хэрэглэгдэж буй багаж материал, тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл, мэс заслын явц зэргийг бүрэн хүлээлцэнэ.

11.8.3 Мэс заслын нэгдүгээр сувилагчийн үүрэг

11.8.3.1 Мэс заслын өмнө

- Хагалгааны өмнө мэс заслын эмчид тухайн хагалгаанд бэлтгэсэн тусгай багаж төхөөрөмж, дутагдалтай зүйлсийг танилцуулна.
- Мэс засалд хэрэглэгдэх багаж, нарийн төвөгтэй мэс ажилбарын багажуудыг нэмэлтээр бэлтгэсэн байх /уушигны самбар, Т-гуурс, үдэгч аппаратуудыг цэнэглэх, цус тогтоогч губка, хамрын чихээс, гипс, чиг, утас, дурангийн хэрэгслүүд, хадаас, гэмтэлийн багаж г.м /
- Хагалгаанд хэрэглэгдэх бор материал, цагаан материал болон дахин хэрэглэгдэх зүйлсийг ариутгалын тасгаас авч, бэлтгэсэн байна.
- Гистологи болон бактериологи шинжилгээ авагдах, эмчлүүлэгчийн нэр бүхий сав бэлтгэсэн байна.

11.8.3.2 Мэс заслын үед

- Стандартын дагуу гар угааж, халад бээлийг өмсөнө.
- Мэс заслын эмч, туслагч нарын гар угаалт, хувцаслалт, халад, бээлий өмсөлтөнд хяналт тавина.
- Багаж хэрэгсэлийн ариутгагдсан индикаторийг шалгаж, 2-р туслах эмчидмэдээлнэ. Хагалгааны өмнө мэс засалдхэрэглэгдэхшарик, салфеткийгчангаар тоолно.
- Хагалгааны талбайг цэвэр байлгах, мөн хагалгааны багын халдварын дэглэм мөрдөлтөнд хяналт тавьна.
- Хагалгаанд хэрэглэж буй багаж материал, шарик салфетка, сорьцын тоог хянаж, 2-р туслах эмчээр хянуулна.
- Хагалгааны явцад хэрэглэх багаж болон утас зүүг зөв сонгон өгнө.
- Хагалгааны үед гадны биет үлдээсэн эсэхийг шалгуулна.

11.8.3.3 Мэс заслын дараа

- Хэрэглэсэн бүх материалыг хураана.
- Хагалгаанд хэрэглэсэн багаж материалыг халдваргүйжүүлж, анхан шатны цэвэрлэгээг хийж, ариутгалын багт хүлээлгэн өгнө.
- Анхан шатны маягтыг журмын дагуу нэг өнгийн үзгээр татлалгүй хөтөлж, нэрээ овгийн эхний үсэгтэй гаргацтай бүтэн бичнэ.
- Хагалгаандорсон өвчтөний бүртгэл хөтөлөж, /журнал/ хадгална.
- Дараа өдрийн хагалгаанд хэрэглэгдэх багаж, материал бэлтгэж ариутгалдөгнө.
- Хагалгааны өрөөний ариун чанар, хагалгааны дараах цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, бактерицид лампын ажиллагааг хариуцна.
- Хагалгаагаар авагдсан эд эсийн шинжилгээнд өгөгдөх /эд эрхтэн/ сорьцийг лабораторт өөрийн биеээр хүлээлгэн өгнө
- Туслах сувилагч болон үйлчлэгчийн ажилд хяналт тавина.
- Мэс заслын сувилагчийн хяналтын хуудсыг бүрэн хөтлөнө.

11.8.4 Мэс заслын хоёрдугаар сувилагчийн үүрэг

11.8.4.1 Мэс заслын өмнө

- Эмчлүүлэгчийг филтер сувилагчаас хүлээж авна.
- Хагалгаанд хэрэглэгдэх хэвлий угаах уусмалуудыг бэлэн байлгана.
- Инженерийн ажиллаж болно гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд цус тогтоогч түлэгч аппаратын идэвхгүй электродын бүрэн бүтэн байдлыг шалгаж, 2-р туслах эмчтэй хамтарч биеийн зохих байрлалд байрлуулна.
- Хагалгаанд хэрэглэгдэх аппарат тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаатай эсэхийг инженерээр шалгуулж хүлээн аваад хагалгааны сувилагчид мэдээлнэ
- Хагалгаанд хэрэглэгдэх бор материал, цагаан материал болон дахин хэрэглэгдэх зүйлсийг ариутгалын тасгаас авч, бэлтгэсэн байна.
- Багаж халдваргүйжүүлэх уусмал бүхий сав бэлтгэнэ.

11.8.4.2 Мэс заслын үед

- Овог нэр, нас, хүйс, онош, хагалгааны нэрийг өвчний түүхтэй тулгаж, өөрөөс нь эдгээрийг давтан асууна.
- Мэс заслын сувилагчийн хяналтын хуудас болон бүртгэлийн хуудсыг бүрэн хөтлөнө.
- Мэс заслын эмч, сувилагч, туслагч нарын гар угаалт, хувцаслалт, халад, өмсөлтөнд хяналт тавьж туслана
- Багаж хэрэгсэлийн ариутгагдсан индикаторийг шалгаж, хагалгааны сувилагч болон 2-р туслах эмчид мэдээлнэ.
- Хагалгааны үед сувилагчид шаардлагатай нэмэлтээр хэрэглэгдэх багаж, материал, эм тариа эмнэлгийн хэрэгсэл, шингэнг авч өгнө.
- Хэрэглэгдэх уусмалын хаягийг эмч, сувилагчид шалгуулна.
- Хагалгаанд хэрэглэгдэх аппарат тоног төхөөрөмжийг хагалгааны явцад залгах, салгах, тохируулах үйлдлийг гүйцэтгэнэ.
- Хагалгааны өрөөний хөл хөдөлгөөнд хяналт тавина.
- Хагалгааны үед отсосоор сорсон шингэний талаар ямар төрлийн шингэн хэдэн мл, литр гарсаныг оператор эмчид мэдээлж байна.
- Хагалгааны явц дунд хэрэглэсэн шарик, салфеткийг цуглуулж, хагалгааны сувилагч тоолж бүртгэсний дараа зориулалтын саванд хийнэ.
- Шаардлагатай тохиолдолд туслах ажилтанг /инженер цахилгаанчин г,м/ дуудна
- Хагалгааны багын халдварын дэглэм мөрдөлтөнд хяналт тавьна.

11.8.4.3 Мэс заслын дараа

- Хагалгаанд хэрэглэсэн материалын зарлагын хуудсыг бүртгэж, туслах эмч болон хагалгааны нэгдүгээр сувилагчаар гарын үсэг зуруулна.
- Хагалгаа дууссаны дараа идэвхгүй электродыг үйлчлүүлэгчийн биенээс салгаж авахад арьс гадаргуу бүрэн бүтэн эсэхийг нэгдүгээр туслах эмчид мэдээлнэ.
- Эмчийн зааврын дагуу гистологийн эдийг шалгаж, тусгай зориулалтын саванд хийж, өвчтөний овог нэр, нас, тасгийн нэрийг савны гадна нааж дагавар бичгийг эмчээр бичүүлэн авна.
- Цус, биеийн шингэн болсон эмнэлгийн хэрэгсэл тоног төхөөрөмжийн гадаргууг халдваргүйтгэлийн бодис бүхий алчуураар арчиж цэвэрлэнэ

- Хагалгааны дараа эмчлүүлэгчийн биеийн бохирлогдсон хэсгийг цэвэрлэж хуурайшуулан
- Үйлчлүүлэгчийг мэс заслын өрөөнөөс шилжүүлэн сэрээх өрөөний сувилагч, болон хяналтын сувилагчид хүлээлгэн өгхөд туслана.
- Хагалгааны өрөөний ариун чанар, хагалгааны дараах цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, бактерицид лампын ажиллагааг хариуцна.
- Туслах сувилагч болон үйлчлэгчийн ажилд хяналт тавина

11.9 Хагалгааны туслах сувилагчийн гүйцэтгэх ажил.

11.9.1 Мэс заслын өмнө

- Эмчлүүлэгчийг филтер сувилагчаас хүлээж авна.
- Хагалгаанд хэрэглэгдэх хэвлий угаах уусмалуудыг бэлэн байлгана.
- Инженерийн ажиллаж болно гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд цус тогтоогч түлэгч аппаратын идэвхгүй электродын бүрэн бүтэн байдлыг шалгаж, 2-р туслах эмчтэй хамтарч биеийн зохих байрлалд байрлуулна.
- Хагалгаанд хэрэглэгдэх аппарат тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаатай эсэхийг инженерээр шалгуулж хүлээн аваад хагалгааны сувилагчид мэдээлнэ
- Багаж халдваргүйжүүлэх уусмал бүхий сав бэлтгэнэ.
- Хог хаягдлын уут, аюулгүйн хайрцгийг бэлэн байрлуулна

11.9.2 Мэс заслын үед

- Овог нэр, нас, хүйс, онош, хагалгааны нэрийг өвчний түүхтэй тулгаж, өөрөөс нь эдгээрийг давтан асууна.
- Хагалгаанд хэрэглэгдэх аппарат тоног төхөөрөмжийг хагалгааны явцад залгах, салгах, тохируулах үйлдлийг гүйцэтгэнэ.
- Хэрэглэгдэх уусмалын хаягийг эмч, сувилагчид шалгуулна.
- Хагалгааны өрөөний хөл хөдөлгөөнд хяналт тавина.
- Хагалгааны үед отсосоор сорсон шингэний талаар ямар төрлийн шингэн хэдэн мл, литр гарсаныг оператор эмчид мэдээлж байна.
- Эмчлүүлэгчийг орон дээр туслах эмч, мэдээгүйжүүлгийн багийнхантай хамт зөв байрлуулж, биеийн дарагдах хэсгийг хамгаална.
- Хагалгааны үед сувилагчид шаардлагатай нэмэлтээр хэрэглэгдэх багаж, материал, эм тариа, шингэнг авч өгнө.
- Хагалгааны явц дунд хэрэглэсэн шарик, салфеткийг цуглуулж, хагалгааны сувилагч тоолж бүртгэсний дараа зориулалтын саванд хийнэ.

11.9.3 Мэс заслын дараа

- Хагалгаанд хэрэглэсэн материалын зарлагын хуудсыг бүртгэж, туслах эмчээр гарын үсэг зуруулна.
- Хагалгаа дууссаны дараа идэвхгүй электродыг үйлчлүүлэгчийн биенээс салгаж авахад арьс гадаргуу бүрэн бүтэн эсэхийг нэгдүгээр туслах эмчид мэдээлнэ.
- Цус, биеийн шингэн болсон эмнэлгийн хэрэгсэл тоног төхөөрөмжийн гадаргууг халдваргүйтгэлийн бодис бүхий алчуураар арчиж цэвэрлэнэ

- Эмчийн зааврын дагуу гистологийн эдийг шалгаж, тусгай зориулалтын саванд хийж, өвчтөний овог нэр, нас, тасгийн нэрийг савны гадна нааж дагавар бичгийг эмчээр бичүүлэн авна.
- Хувцас солих өрөөг цэгцэлж, цэвэрлэгээг үйлчлүүлэгчээр хийлгэж, хүлээн авна.
- Хяналтын сувилагчаас хэрэглэгдсэн хувцаснуудыг тоолж, зориулалтын уутанд хийж, угаалганд хүлээлгэн өгнө.
- Хагалгаанд өмсөх хослолыг угаалгын тасгаас тоолж, хүлээн авч, хяналтын сувилагчид хүлээлгэн өгнө.
- Бохирдсон багаж хэрэгслийг шууд халдваргүйтгэлийн уусмалд хийнэ.
- Хог хаягдлыг зориулалтын уут болон аюулгүй хайрцагт хийж битүүмжлэн хаяг тавьж, устгалд шилжүүлнэ.
- Хагалгааны ор, хормогч халдваргүйтгэлийн уусмалаар арчиж цэвэрлэнэ.
- Гистологийн эд бүхий шил, уутанд формалины уусмал хийнэ.
- Хагалгааны дараах тоног төхөөрөмжийн цэвэрлэгээг чанартай хийнэ.
- Бохирлогдсон халад, даавууг зориулалтын тэргэнцэрт хийж, угаалганд тоолж, хүлээлгэн өгнө.
- Өмссөн табчикнуудыг ариутгалын уусмалаар угаана.
- Үйлчлэгчийн ажилд хяналт тавина.

11.10 Хяналтийн сувилагчийн үйл ажиллагаа

11.10.1 Хяналтын сувилагчгүй бол хагалгааны туслах сувилагч үүргийг гүйцэтгэнэ.

11.10.2 Мэс заслын өмнө

- Мэс засалд өмсөх зориулалтын хувцасны иж бүрдлийг шаардлагатай хэмжээгээр бэлтгэнэ.
- Хагалгааны блокруу орох ажилчдын хувцаслалтанд хяналт тавина.
- Тасгаас ирсэн эмчлүүлэгчийг өвчний түүхийн хамт палатны сувилагчаас хүлээж авна. Палатны сувилагчаас овог нэр, ямар хагалгаа хийлгэх талаар тодорхой лавлаж, бүртгэл хөтөлнө. Хяналтын сувилагч байхгүй тохиолдолд мэдээгүйжүүлгийн сувилагч үүргийг гүйцэтгэнэ
- Өвчтөний овог нэр, насыг өөрөөс нь сонсогдохоор асууж магадлан, түүхэнд бичигдсэн нэртэй тулгаж хагалгааны төлөвлөгөөнд итэмдэглэсний дараа мэс засал, унтуулгын туслах эмч болон сувилагчид хүлээлгэн өгнө.
- Хагалгааны төлөвлөгөөнд эмчлүүлэгч, хагалгааны багийн орсон, гарсан цагийг тэмдэглэж, хагалгаа ороогүй хойшлогдсон, нэмж орсон хагалгаануудыг шалтгаантай нь тодорхой бичнэ.
- Ажилчдаас бусад хүмүүсийн зөвшөөрлийн бичгийг шалгаж оруулна. Зөрчилтэй тохиолдолд оруулахгүй бөгөөд холбогдох албан тушаалтанд мэдэгдэнэ.
- Эмчлүүлэгчийн шинжилгээг хянаж, элэгний ДОХ, ХДХВ, тэмбүү, В, С вирус эерэг тохиолдолд анхааруулах бичгийг хагалгааны өрөөний үүдэнд хадна.

11.10.3 Мэс заслын үед

- Хагалгааны хэсгийн хөдөлгөөнд хяналт тавина.
- Эхний хагалгаа дуусахад, дараагийн эмчлүүлэгчийг шуурхай дуудна.

- Хагалгааны дараа сэрээх өрөөний сувилагчаас эмчлүүлэгчийг хүлээн авч, палатны сувилагчид хүлээлгэн өгнө. Хяналтын сувилагч байхгүй тохиолдолд мэдээгүйжүүлгийн сувилагч гүйцэтгэнэ
- Зөрчил гарсан тохиолдолд тасгийн эрхлэгч, ахлах сувилагчид нэн даруй мэдэгдэнэ.
- Шаардлагатай тохиолдолд инженер, сантехникийн болон бусад ажилчдыг дуудна.

11.10.4 Мэс заслын дараа

- Хэрэглэгдсэн хувцсыг тоолж, туслах сувилагчид хүлээлгэн өгнө.
- Анхан шатны бичиг баримтыг хөтөлнө.

11.11 Хагалгааны үйлчлэгч

11.11.1 Мэс заслын өмнө

- Хагалгаа эхлэхээс 30 минутын өмнө халдваргүйтгэлийн бодис бүхий чийгтэй цэвэрлэгээ хийнэ.

11.11.2 Мэс заслын үед

- Хагалгааны явц дунд цус, биеийн шингэн болсон шал, гадаргууг халдваргүйтгэлийн бодис бүхий алчуураар арчиж цэвэрлэнэ.
- Эмч, сувилагч нарын удирдлагаар шаардлагатай ажлыг гүйцэтгэнэ.
- Хагалгааны явцын цэвэрлэгээг чанартай хийнэ.
- Туслах сувилагч байхгүй тохиолдолд түүний үүргийг гүйцэтгэнэ.

11.11.3 Мэс заслын дараа

Хагалгааны өрөөний шалыг халдваргүйтгэлийн уусмалаар арчиж цэвэрлэнэ.

Арван хоёр. Мэс заслын тусламж үзүүлдэг нэгжийн ЭТҮХХ-аас сэргийлэх үйл ажиллагаа

12.1 Мэс заслын өрөөнд бусад ажилчид шаардлагатай тохиолдолд орох

12.1.1 Хагалгааны хэсэгт үйлчилгээний ажилчид орох

- Инженер, сантехникийн слесарь, цахилгаанчид хагалгааны хэсэгт орохын өмнө зориулалтын хувцасыг өмсөнө.
- Шаардлагатай багаж хэрэгсэлийг урьдчилан бэлтгэж ирнэ.

12.1.2 Суралцагсад хагалгааны блокт нэвтрэх

- Мэргэжил олгох болон дээшлүүлэх, дадлагажих сургалтанд хамрагдагсад сургалтын албанаас зөвшөөрөл олгосон тохиолдолд сургалт удирдаж байгаа эмч, багш нар тасгийн эрхлэгч, ахлах сувилагчтай урьдчилан тохиролцож, стандартын дагуу хувцас өмсгөж оруулна.
- Суралцагсад тасагт орохын өмнө "Мэс заслын тусламж үйлчилгээний журам", "Мэс заслын аюулгүйн хяналтын хуудас хэрэгжүүлэх" журмуудтай танилцсан байна.
- Суралцагсад В вирус, С вирус, дельта вирус, тэмбүү ХДХВирус, залгиур, шимэгч хорхойн шинжилгээ өгсөн байна.
- Хяналтын болон хагалгааны сувилагч нарын шаардлагийг биелүүлэх бөгөөд хүний тоо ихэссэн болон онцгой тохиолдолд оруулахгүй байх эрхтэй.

- Хагалгааны өрөөнүүдэд эмч, сувилагчийн хяналтан дор үйл ажиллагаанд оролцоно.

12.2 ХНТасгийн ХСХ

- 12.2.1 Бүх ажилтнууд ЭТҮХХалдварыг баримтлахын зэрэгцээ эмнэлгийн бусад үйлчлүүлэгчдэд олон эмэнд дасалтай нянгийн халдвар тараахаас чанд сэргийлнэ.
- 12.2.2 Гарыг халдваргүйжүүлэх аргыг эрүүл мэндийн бүх ажилтнууд дараах зааврыг мөрдөнө. Халдваргүйжүүлэх хугацаа 20-30 секундээс багагүй байна.
- 12.2.3 Спиртэн суурьтай гар халдваргүйтгэлийн бодисийг бүх ажилтнууд дараах зааврын дагуу хэрэглэнэ:
- Эмчлүүлэгчийн өрөөнд орохын өмнө болон орсны дараа (хаалга, хөшиг, орны орчим гэх мэт)
 - Бээлий өмсөхийн өмнө
 - Эмчлүүлэгчид хүрэхийн өмнө болон хүрсний дараа
 - Эмчлүүлэгчийн орчинд хүрэхийн өмнө болон хүрсний дараа
- 12.2.4 Дараах тохиолдлуулал гараа савандаж угаах ба гараа савандаж угаах хугацаа 1 минутаас багагүй байна.
- Цус, бусад биеийн шингэнд хүрэлцсэний дараа
 - Гар бохирдсон үед
 - Бээлий тайлсны дараа
- 12.2.5 Эмчлүүлэгчийн өрөөнд орохын өмнө нэг удаагийн хамгаалах хувцас өмсөх ба гарахдаа тайлна.
- 12.2.5.1 Бээлий- Эмчлүүлэгчийн биеийн шингэн, боолт, шарханд хүрэх бүх тохиолдолд нэг удаагийн бээлий өмсөнө. Эмчлүүлэгч хооронд бээлийг заавал солино.
- 12.2.5.2 Нэг удаагийн халад, малгай - Олон эмийн тэсвэртэй нянтай эмчлүүлэгчид том талбайгаар хүрэлцэх үед (эмчлүүлэгчийг эргүүлэх, өргөх гэх мэт)
- 12.2.5.3 Амны хаалт, нүүрний хамгаалалт, нүдний шил
- Мэс заслын амны хаалтыг эмнэлгийн бүх ажилтан, 2 цаг тутамд сольж тогтмол зүүнэ
 - N95 маск, нүүрний хаалтыг амьсгалын замын соруулга, интубаци тавих авах, амьсгалын замаас сорьц авах үйлдэл хийх
 - Нүдний шил, нүүрний хаалтыг асгарсан цацагдсан биологийн шингэнийг цэвэрлэх, өвчтний биеийн хэсэгчилсэн угаалга хийх, хагалгааны явцад соруулсан шингэн, өтгөн шингэнийг ОО- д асгах зэрэгт заавал хэрэглэнэ.
- 12.2.6 Мэс заслын үед гар угаах
- 12.2.6.1 Мэс заслын өрөөний угаалтуур нь хөл, тохиогоор ажилладаг эсвэл мэдрэгчтэй, зэвэрдэггүй ган материалаар хийгдсэн байна. Тосгуур нь тохой хүртэл гар угаахад шүргэхээргүй, ус цацагдахааргүй том хэмжээтэй байна. Угаалтуурын ханын хэсэг нь ус нэвтэрдэггүй, цэвэрлэхэд тохиромжтой материалаар хийгдсэн байна.

- 12.2.6.2 Гар угаах халдваргүйжүүлэх бодис нь мэс заслын гар угаалтанд зориулагдсан байна.
- 12.2.6.3 Гар угаах усны хэм, урсгалыг тохируулан тохойноос урагш хэсгийг сайтар норгосны дараа нэг удаагийн хэрэглээний губка ашиглан гарын алга, ар тал, хуруунуудын завсар, хумь бугуйнаас тохой хүртэл сайтар үрж 5 минутаас багагүй хугацаанд үрж угаана.
- 12.2.6.4 Цэвэр усаар булхуулж саванг бүрэн гүйцэт арилгасны дараа арчиж хатаана.
- 12.2.7 Тусгарлан сэргийлэх тусламж ба нэмэлт хамгаалалтын тэмдгийг хэрэглэх
- 12.2.7.1 Дараах тэмдэглэгээг эмчлүүлэгчийн өрөөний гадна, мэс заслын өрөөнд байрлуулна:
- Улаан – олон эмэнд дасалтай нян / хавсралт -3 /
 - В, С вирустай эмчлүүлэгчийг таних тэмдэг /хавсралт -4/
- 12.2.8 Урсгалын хяналт
- 12.2.8.1 Тасагт нэвтрэх хүмүүсийн хөдөлгөөнийг бага байлгана.
- 12.2.8.2 Мэс заслын дараа сахиур шардлагатай тохиолдолд сахиур бүрэн хувцасаа сольсон, гарч орохгүй солигдохгүй байх шаардлага тавина.
- 12.2.9 Мэс заслын тусламж үзүүлдэг нэгжүүдийн халдвар хамгааллын дэглэмийн багцууд:
- Давсагны гуурс, катетрын багц
 - Боолтын багц
 - Өртөлтийн дараах сэргийлэлтийн багц
 - Асгарсан цацагдсан биолгийн шингэнийг цэвэрлэх үеийн г.м
- 12.2.10 Амбулаторийн болон өдрийн зарим мэс ажилбарын үед хэрэгжүүлэх үйл ажиллагаа
- 12.2.10.1 Ажилбар хийгдэж байгаа бүх тохиолдолд асептик дүрмийг баримтална
- 12.2.10.2 Гарыг мэс заслын гар угаах техникийн дагуу зориулалтын сойзоор тохойноос ургаш угааж, халдваргүйтгэнэ.
- 12.2.10.3 Хийгдэж байгаа ажилбарын талбайн хэмжээ хүрцээс хамаарч Ариун хамгаалалт: халат, маск, малгай, ариун бээлий, ариун тусгаарлах хаалт хэрэглэнэ.
- 12.2.10.4 70%-ийн спирт, тамедин 0.7%, 2,5%, 7,5%, хлоргексидины 2,5% уусмаар арьсыг арчиж ажилбарын талбайг халдваргүйтгэнэ.
- 12.2.10.5 Ажилбарыг гүйцэтгэж буй хүн хурц үзүүртэй бүх зүйлийг аюулгүй хайрцагт хаяж хэвшсэн байна (зүү, хутганы ир зэрэг).
- 12.2.10.6 Ажилбар бүрт нэг ариун цомог задалж ажилбарыг дуусгана.
- 12.2.11 Ариун материал хадгалах зөөвөрлөх, хэрэглэх
- 12.2.11.1 Ариун материалын хадгалалт хамгаалалт, хэрэглээ
- Мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлдэг хэсэг нь ариун материал хадгалах зориулалтын шүүгээтэй байна.
 - Ариун материал тээвэрлэх явцад ариун байдлыг хамгаалах, цохих, бутлах, тахийлгах мурийлгах, унагаах гэмтэл гаргахаас сэргийлнэ.
 - Ариутгагдсан зүйл шалан дээр унахад ямар нэгэн гэмтэлгүй байсанч бохирлогдсон гэж үзнэ
 - Зориулалтын савалгаа /рулон ууттай / боолттой, бүрэн бүтэн байдал алдагдаагүй, гадна тал бохирдоогүй, ариун материал нь хадгалах

зориулалтын шүүгээнд хадгалсан бол ариутгасан багажийг 6 сар, бикстэй бол 72 цаг, рулон ууттай бол -14, даавуун боолттой бол 7 хоног хадгална.

12.2.11.2 Ариутгалд материал өгөх авах

- Ариутгалын тасаг нь хагалгааны төлөвлөгөөний дагуу хагалгаанд хэрэглэгдэх багаж материал эм эмнэлгийн хэрэгсэл туслах материалыг бэлтгэж ариутгана.
- Ариутгалын тасаг нь байнгын нөөцтэй байж, яаралтай болон төлөвлөгөөт хагалгаанд хэрэглэгдэх материалыг бүрэн хангана.
- Хагалгааны сувилагч нар өглөө бүр 09.00-09.30 цагийн хооронд, үдээс хойш төлөвлөгөөт хагалгаа дуусмагц 19.00 цаг хүртэл хагалгааны материалыг ариутгалын тасагт авчирч өгнө.
- Хагалгааны сувилагч нь оройн 20 цагаас өмнө тухайн ээлжинд хэрэглэгдэх ариутгагдсан багаж материалыг төвлөрсөн ариутгалаас авна
- Хагалгааны сувилагч нь өдөр тутмын хагалгаанд хэрэглэгдэх багаж материалыг ажлын цагаар өглөө бүр 08.30-д, орой 19.30 цагт ариутгалын тасгийн бэлтгэлээс авсан байна.
- Хагалгааны сувилагч нар нь бэлтгэлийн тооцооны хуудсан дээр хэрэглэгдсэн цагаан материалын зарлагын тэмдэглэл тооцоог хөтөлж, нэрээ гаргацтай бичнэ.
- Хагалгааны сувилагч нар нь ариутгагдсан биксийг хагалгааны төлөвлөгөөний дагуу байрлуулж, ариутгалын хүчинтэй хугацаанд хэрэглэгдээгүй бикс гаргахгүйгээр ажиллана

12.2.12 Эрүүл зүйн шинжилгээнд хамрагдах

- Орчны агаарын болон арчдасын шинжилгээг улирал тутам авч дүгнэлт гарган шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.
- Эмч эмнэлгийн мэргэжилтний нян тээгч илрүүлэх шинжилгээг улирал тутам хийж нян тээгчийг илрүүлэн эмчилэн эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- ЭТҮХХ-ийн сэжигтэй тохиолдолд бүрт халдварын эрсдлийг тогтоох шинжилгээ, тандалт судалгааг зааврын дагуу хийж хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.

12.2.13 Мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлдэг нэгжид цэвэрлэгээ хийх

ЭЭН нь ЭМСын 2019 оны 537 тоот тушаалын 6 дугаар хавсралтын дагуу дагуу халдварын өндөр эрсдэлтэй бүсэд хамаарах ба цэвэрлэгээг өдөрт гурваас доошгүй удаа хийж бүртгэл хөтөлж баримтжуулсан байна.

- Хагалгаа эхлэхээс 30 минутын өмнө халдваргүйтгэлийн бодис бүхий чийгтэй цэвэрлэгээ хийж, кварцын лампыг ажиллуулна.
- Хагалгаа хооронд агаарыг 3%-ын перкисийн уусмалаар шүршиж ариутгана.
- Хагалгааны дараа зөөврийн агаар шүүгч аппаратыг зааврын дагуу ажиллуулна.
- Хог хаягдал, бохирдсон даавуу материалыг гарсан тухай бүрд нь зориулалтын саванд хийнэ.

- Хог хаягдлыг уут болон аюулгүй хайрцагт хийж битүүмжлэн хаяг тавьж устгалд шилжүүлнэ.
 - Их цэвэрлэгээ хийхдээ холбогдох тушаал, зааврын дагуу долоохоног бүр нэг удаа хагалгааны бүх өрөөг суллаж хийх ба тоног төхөөрөмжийн засвар, эд юмсын халдваргүйтгэл, агаарын ариутгал хийнэ.
 - Бохир хагалгаа орсон тохиолдол бүрд агаарын ариутгал хийнэ
- 12.2.14 ХДХВ -тэй болон эрсдэлтэй халдвартай эмчлүүлэгч хагалгаанд орох үед баримтлах зарчим
- 12.2.14.1 ХДХВ-ийн халдвартай үйлчлүүлэгч ирсэн тохиолдолд жижүүрийн ахлах эмч нь халдвар судлаач эмч, ЭЭДЗахирал, хагалгааны багийнханд мэдэгдэнэ.
- 12.2.14.2 Хагалгааны багийнхан ХДХВ -тэй эмчлүүлэгчийн эрхийг хүндэтгэн харьцах ба нууцыг чандлан хадгална.
- 12.2.14.3 ВГВ, ВГС, ХДХВ-ийн халдвартай өвчтөндтусламж үзүүлэх багийнхан нь хагалгааны өмнө эрсдэлд өртөхөөс сэргийлж, ажиллах санамжтай танилцана.
- 12.2.14.4 ХДХВ -тэй өвчтөнд хагалгаа хийх нэг удаагийн хэрэгслийн хангалт, сэлбэлтийг ЭЭДЗахирал хариуцна.
- 12.2.14.5 ХДХВ-тэй болон эрсдэлтэй халдвартай эмчлүүлэгчид хагалгаа хийж дууссаны дараа халдваргүйтгэлийг онцгойлон гүйцэтгэж, цэвэрлэгээг халдвар судлаачийн хяналтан дор хийнэ
- 12.2.14.6 ХДХВ -ийн халдвартай өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлсэн тухай протоколийг тухайн эмчлэгч эмч хөтлөх ба хяналт тавьж ажилласан илтгэх хуудсыг халдвар судлаач эмч хөтөлж, ХӨСҮТ, ЭМГ-ын ДОХ/БЗДХ-ийн албандмэдээлнэ.
- 12.2.15 Хог хаягдлыг ангилан устгах
ЭМС-ын 2017 оны 505 тоот тушаалын дагуу ангилан ялгаж түр хадгалах цэгт төвлөрүүлнэ.

Арван гурав. Аюулгүй орчныг бүрдүүлэх

- 13.1 Анхаарах зүйл
- 13.1.1 Хагалгаа дуусаагүй нөхцөлд зориулалтын хувцастай эргэж гарахгүй байх
- 13.1.2 Мэс заслын өрөөнд зөвшөөрөл олгогдоогүй хүмүүс орохыг хориглоно.
- 13.1.3 Бүх ажилбарын явцад өрөөний хаалганууд хаалттай байна.
- 13.1.4 Мэс заслын үед цус болон биеийн бусад шингэнээр хэт бохирлогдсон даавуу, халат, бээлийг тохиолдол бүрт солино.
- 13.1.5 Хүчилтөрөгч, вакуум, закись, азот, нүүрсхүчлийн хийтэй зааврын дагуу ажиллана. Хийтэй ажиллах аюулгүй ажиллагааны журам, баллоны гадуур тусгаарлах ууттай байхын зэрэгцээ онцгойлох тэмдэг бүхий байна.
- 13.1.6 Хувцас солих өрөөнд цэвэр бохир урсгалыг зөв баримтлана.
- 13.1.7 Хагалгаанд орох, гарах тохиолдол бүрт эмчлүүлэгчид цэвэр даавуу хэрэглэнэ.
- 8.1.8 Гар угаах ба багаж угаах крантыг тусгаарлаж ашиглана.
- 13.2 Гал гарсан тохиолдолд
- 13.2.1 Галын хор хүрэлцээт хэмжээгээр хагалгааны блок бүрт 2 ш байх зориулалтын тавиурт байрлуулсан байна.
- 13.2.2 Өдрийн цагаар гал гарсан тохиолдолд инженер техникийн ажилтнууд болон байгууллагын удирдлагуудад, ажлын бус цагаар жижүүрийн ахлах эмчид яаралтай мэдэгдэнэ.

- 13.2.3 Хагалгаа явагдаж байгаа тохиолдолд гал гарвал эмчлүүлэгчийг яаралтай гаргаж, гал унтраах арга хэмжээг авна.
- 13.2.4 Шаардлагатай үед галын хорыг зааврын дагуу ажиллуулах чадварыг бүх ажиллагсад сургасан байна.
- 13.3 Цахилгаан тасарсан тохиолдолд
 - 13.3.1 Цахилгаан тасарсан тасгийн ахлах сувилагч инженер техникч нарт мэдэгдэн, шалтгааныг тодруулж, саатлыг арилгуулах арга хэмжээ авна.
 - 13.3.2 Хагалгааны өрөөнд цахилгаан үүсгэврийг /хонда мотор/ бэлэн байлгаж саадгүй ажиллуулах техникийн байдлыг инженер техникийн ажилтан хариуцна.
 - 13.3.3 Тасгийн ажилчид цахилгаан үүсгэврийг ажиллуулах арга барилд суралцсан байна.
 - 13.3.4 Хонда моторын хэрэгцээний шатахуун тослох материалыг тасаг хариуцан нөөцлөж, тусгай сав, байранд хадгална.
 - 13.3.5 Цахилгаан үүсгэвэр мотор байгаа өрөөний түлхүүрийг тасгийн жижүүрийн ажилчдадбайнгын бэлэн байлгана.
 - 13.3.6 Цахилгаан тасарсан үедхонда моторыг, аюулгүй ажиллагааны зааврын дагуу ажиллуулна.
 - 13.3.7 Хонда моторын аюулгүй ажиллагааны заавар, ажиллуулах журам, тасгийн ажилчдыг сургах асуудлыг хагалгааны сувилагч цахилгааны инженер нар хариуцан хийнэ.
- 13.4 Тоног төхөөрөмж эвдэрсэн тохиолдолд
 - 13.4.1 Хуучирсан, тусламжаар ирсэн аппаратны ашиглалтын хугацаа, үйл ажиллагааны эрсдэл зэргийг мэргэжлийн инженерээр үнэлүүлж, гэмтлийг тогтооно.
 - 13.4.2 Хугацаа нь дуусаагүй шинэ тоног төхөөрөмжийг гэмтээж, эвдсэн тохиолдолд техникийн комисс томилон, үнэлгээ хийлгэн, буруутай этгээдэд хариуцлага тооцно.
 - 13.4.3 Аппарат тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд хагалгаанд хэрэглэж болохгүй шийдвэрийг хариуцсан инженер гаргаж, удирдах албан тушаалтанд мэдээлнэ.

Арван дөрөв. Эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдал

- 14.1 Хагалгаа, мэдээгүйжүүлэгт хэрэглэх эм эмнэлгийн хэрэгслийн захиалга, хэрэглээний тооцоо, тооллогыг эм зүйч хариуцаж, хагалгаанд хэрэглэгдэх эм эмнэлгийн хэрэгслийн хүртээмж, чанар, зохистой хэрэглээ зэрэгт хяналт тавьж ажиллана.
- 14.2 Хагалгааны төлөвлөгөөг үндэслэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгыг эмчлүүлэгч нэг бүрийн нэрээр хийж эмийн сангаас авч тус тусад нь савлан бэлтгэнэ.
- 14.3 Хагалгаа эхлэх үед эмчлүүлэгч нэг бүрийн эм эмнэлгийн хэрэгслийг хагалгааны өрөөнд хүргэн өгнө. Ажлын цагт яаралтай тохиолдолд шаардлагатай /яаралтай шүүгээндбайхгүй/ эмийг эмийн сангаас нэмэлт захиалгаар шуурхай хүргэн өгнө.
- 14.4 Хэрэглэгчдэд түгээсэн эмийн тооцоог өдөр бүр компьютерт шивж, сар бүрийн эцэст эмийн ня-бо тайлагнана. Улирлын эцсээр өөрийн хариуцсан тасгийн эмийн хэрэглээний товчоог эмийн санд өгч нэгтгүүлнэ.
- 14.5 Хагалгааны тухайн хэсэгт яаралтай шүүгээндбайх эм эмнэлгийн хэрэгслийн тоохэмжээг тогтоон ЭЭО даргаар баталгаажуулалт хийлгэх ба уг шүүгээнд буй эмийн хадгалалт, зарцуулалтын байдалд хяналт тавьж ажиллана.
- 14.6 Сар бүрийн 25-нд хагалгааны хэсгийн “А” шүүгээний эмийг тоолуулж, тайлан балансыг гаргана.

- 14.7 Хадгалалтын онцгой нөхцөл шаардагдах эмүүдийг хөлдөөгч, хөргөгч болон тусгай шүүгээнд хадгалах байгалд тэсрэмтгий, ууршимтгай шингэнэнүүдийг төмрөөр доторлосон шүүгээнд гадны нөлөөлөл, гал, усны аюулаас хамгаалсан нөхцөлд хадгална.
- 14.8 Хадгалалтын буруугаас эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, байдлыг алдагдуулсан, хэрэглээний хугацаа хэтрүүлсэн тохиолдолд хариуцлага хүлээн, эмийн үнийг нөхөн төлж, байгууллагыг хохиролгүй болгоно.
- 14.9 Хагалгаанд хэрэглэгдэж буй эм эмнэлгийн хэрэгслийн хүртээмж, чанар, зохистой хэрэглээ зэрэгт хяналт тавьж, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд эм зүйн мэргэжлийн зөвлөлгөө өгч ажиллана.

Арван тав. Ажлын байрны ёс зүй

- 15.1 Хагалгаанд орж буй багийнхан эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг чандлан сахиж, байгууллагын ёс зүйн болон дотоод журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.
- 15.2 Хагалгааны багийнхан эмчлүүлэгчийн дэргэд маргалдах, чанга ярихийг хориглоно. Зөрөлдөөнтэй асуудал гарвал аль болохоор эв зүйгээр шийдэхийг оролдох бөгөөд боломжгүй тохиолдолд холбогдох хүмүүст мэдээлнэ.
- 15.3 Ажлын байрны ёс зүйг эрхэмлэн, гаж, этгээд үг хэллэг хэрэглэхгүй байх.
- 15.4 Бие биенээ гутаан доромжилсон үгээр дайрах, эсвэл хэт найрсаг харилцаа гаргахыг хориглоно.
- 15.5 Ажлын байрыг шалтгаангүйгээр орхиж явахыг хориглоно. Зайлшгүй тохиолдолд мэс заслын багийнханд мэдэгдэнэ.
- 15.6 Хагалгаа хийгдэж байхадгар утас хэрэглэхгүй байх.
- 15.7 Хагалгааны үр дүнгийн талаар хагалгаа дууссаны дараа зөвхөн оператор эмч үйлчлүүлэгчийн ар гэрийхэнд мэдээлэл өгнө.
- 15.8 Үйлчлүүлэгчийн болон оператор эмчийн зөвшөөрлөөр ар гэрийхэнд хагалгааны эдийг /эд, эрхтэнийг/ үзүүлж танилцуулна.

Арван зургаа. Гадаадын мэргэжилтэн,бусад эмнэлгийн эмч ажиллуулах , бусад ЭМБ -д мэс засал хийх үеийн зохицуулалт

- 16.1 Гадаад улс, бусад байгууллагаас ирж хагалгаа, мэдээгүйжүүлэг хийх эмч нарын асуудлыг тухайн тасгийн эрхлэгч хариуцах бөгөөд ЭЭДЗахиралаас бичгээр зөвшөөрөл авна.
- 16.2 Хамтарсан мэс заслыг энэ хүү журмын холбогдох заалтын дугуу гүйцэтгэнэ. Ажлын бус цагаар хийх бол Төвийн захирал, ЭЭДЗахирал нарт заавал мэдэгдэж шийдвэр гаргуулсан байна.
- 16.3 Гадаад эмч бусад ЭМБ-ын эмч хагалгаа хийгээд явсан тохиолдолд эмчлүүлэгчийг тухайн эмчтэй хамтран ажилласан эмч /тасгийн эрхлэгчийн зөвшөөрлөөр/ үзэж, эмчилгээг хянанна.
- 16.4Тасгийн үйл ажиллагаатай танилцах гадаадын эмч, сувилагч, оюутан нар байгууллагын удирдах ажилтан болон Сургалтын албанаас бичгээр зөвшөөрөл авсан байна.
- 16.5 Яаралтай тусламж, алсын дуудлагаас бусад тохиолдолд тус төвийн мэс заслын тусламж үзүүлэгч эмч нарыг бусад эрүүл мэндийн байгууллага дээр мэс засал хийхийг хатуу хориглоно.
- 16.6 Яаралтай тусламж, алсын дуудлагаар бусад эмнэлэгт мэс засал, мэс ажилбар хийх үед зайлшгүй шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийг

дуудлагын баг бэлтгэн авч явж болох ба энэ тохиолдолд ЭЭДЗахиралаас зөвшөөрөл авсан байна.

Арван найм. Мэс заслын тасагт гадны хүн нэвтрэх журам /хүнд өвчтөний ар гэрийхэн, цагдаагийн ажилтан/

- 18.1 Тасгийн эрхлэгч, эмчлэгч эмчийн зөвшөөрлөөр тасгийн хэвтэн эмчлүүлэгчийн өрөөнд орохыг зөвшөөрнө.
- 18.2 Гадны хүн нэвтрэхэд халдвар хамгааллыг тасгийн жижүүрийн үйлчлэгч хариуцна.
- 18.3 Гадуур хувцасыг тайлж, цэвэр, шороо тоосгүй хувцастай байна
- 18.4 Эмнэлгийн зориудын нөмрөг, малгай, углааш өмсөнө.
- 18.5 Маш хүнд өвчтөний өрөөнд ар гэрээс 2-3 хүн байлгахыг зөвшөөрөх ба бусад өвчтөний тайван байдлыг алдагдуулахгүй байх, хагалгаатай хэсгийн шаардлагын дагуу хувцас солих, эмнэлгийн зориудын нөмрөг, малгай, углааш өмсөнө.

Арван ес. Журам зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээ

- 19.1 Энэхүү журам зөрчсөн буруутай этгээдийг гарсан зөрчил, хохирлын байдлаас шалтгаалан хөдөлмөрийн хууль, байгууллагын дотоод журам, холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авна.

ЭМС-ын 2009 оны 388 тоот тушаал, 2019 оны а/293 тоот тушаалын дагуу БОЭТ-ийн яаралтай тусламжийн үйлчилгээнд хэрэглэгдэх эм, тариа, нэг удаагийн хэрэгслийн жагсаалт

№	Эмийн олон улсын буюу ерөнхий нэршил	Тун хэмжээ	Хэмжих нэгж/хэлбэр	Доод хэмжээ
1.Ерөнхий мэдээгүйжүүлэг бэлдмэл				
1	Тиофентал натри	0.5г-1г	фл	30
2	Пропофоль	200мг/20мл	фл	10
2. Булчин сулруулах, холинэстразийн эсраг бэлдмэл				
3	Прозерин/ неостигмин /	0.5мг/мл	ам	30
4	Тракриум	25 мг/2,5 мл	ам	30
5	Суксаметаниум	100 мг/2 мл	ам	10
3. Хэсгийн мэдээгүйжүүлэх бэлдмэл				
6	Лидокайн	2%-2мл	ам	30
7	Новокайн	0,25%-100мл	фл	2
8	Бупивакаин	4,0	ам	50
9	Изобупиваин	2,0	ам	20
4.Зүрх судасны үйл ажиллагааг дэмжих				
10	Эпинефрин	0,1%-1мл	ам	30
11	Допамин	0,5%-5мл	ам	10
12	Амиодарон	150мг/3мл	ам	10
13	Атропин сульфат	0,1%-1мл	ам	5
5.Цусны даралт бууруулах				
14	Эналаприл	1,25мг/1мл	ам	10
15	Никардипин	1мг/мл	ам	10
6.Гуурсан хоолойн агчлын үед хэрэглэх				
16	Аминофиллин	2,4мг/ам-10мл	ам	5
17	Сальбутамол		фл	4
7.Харшлын ба анафилаксийн эсрэг				
18	Преднизолон	30мг-1мл	ам	5
19	Дексаметазон	4мг/1мл	ам	20
8.Өвдөлт намдаах, халуун бууруулах				
20	Метамизол натри	50%-2мл	ам	30
21	Ревалгин	5мл	ам	5
22	Дифенгидрамин /димедрол/	1%-1мл	ам	10
23	Диклоденк	100мг	лаа	10
24	Ацетаминофен 125	125мг	лаа	10
25	Ацетаминофен 250	250	лаа	10
9.Цусны бүлэгнэлтэнд нөлөөлөх				
26	Аминокапроны хүчил	5%-100мл		5
27	Транексамын хүчил	50мг/5мл	ам	30
28	Дицинон	125мг/2мл	ам	10
10.Цусны бүлэгнэлтийн эсрэг				
29	Гепарин	5000ед-1мл	фл	5
11.Калийн бэлдмэл				
30	Кальцийн хлорид	10%-10мл	ам	10
31	Калийн хлорид	7,5%-100мл	фл	2

12.Шингэнүүд				
32	Натрийн хлорид	0.9%-100мл	фл	10
33	Натрихлорид	0,9%-250 мл	фл	10
34	Натрийн хлорид	0.9%-500мл	фл	60
35	Рингерийн уусмал	250мл	фл	5
36	Рингерийн уусмал	500мл	фл	5
37	Глюкоз	5%-500мл	фл	3
38	Глюкоз	40%-40мл	ам	30
39	Глюкоз	5%-250мл	фл	3
40	Глюкоз	5%-100мл	фл	3
41	Маннитол	100мл	фл	5
13.Бөөлжилтийн эсрэг				
42	Метоклопрамид	0,5%-2мл	ам	10
14.Витаминууд				
43	Аскорбины хүчил	5%-2мл	ам	20
15.Нүдний бэлмэл				
44	Прокайн		фл	1
16.Мансууруулах, сэтгэц нөлөөт эм, тариа				
45	Морфин гидрохлорид	10мг/мл-1мл	ам	2
46	Диазепам	10мг-2мл	ам	2
47	Фентанил	0.0005%-2мл	ам	30
48	Дроперидол	5мг/мл-2мл	ам	2
49	Кетамин	500мг/10 мл	фл	5
17.Нэг удаагийн хэрэгсэл				
50	Эмнэлгийн вазелин	20гр	түб	1
51	Изофлуран	200 мл	фл	2
52	Севофлуран	200 мл	фл	1
53	Халотон	200 мл	фл	1
54	Адсорбент	10 л	Фл	1
55	Бинт	Нэг удаагийн	ш	5
56	Ходоодны зонд	Нэг удаагийн	ш	10
57	Катетр	Нэг удаагийн	ш	10
58	Шээсний уут	Нэг удаагийн	ш	10
59	Дуслын систем	Нэг удаагийн	ш	25
60	Нугасны хатгалтын зүү /27G/	Нэг удаагийн	ш	50
61	Тариур	1гр	ш	30
62	Тариур	3гр	ш	50
63	Тариур	5гр	ш	50
64	Тариур	10гр	ш	50
65	Тариур	20гр	ш	30
66	Уян зүү	18G	ш	10
67	Уян зүү	20G	ш	10
68	Уян зүү	22G	ш	10
69	Уян зүү	24G	ш	10
70	Трубка № 8	Нэг удаагийн	ш	10
71	Трубка №7,5	Нэг удаагийн	ш	10
72	Трубка №7,0	Нэг удаагийн	ш	10
73	Трубка № 6,5	Нэг удаагийн	ш	10
74	Трубка №6,0	Нэг удаагийн	ш	10

Мэс заслын тусламж үйлчилгээний журам 2023 он

75	Трубка №5,5	Нэг удаагийн	ш	10
76	Трубка №5,0	Нэг удаагийн	ш	10
77	Трубка №4,5	Нэг удаагийн	ш	10
78	Трубка №4,0	Нэг удаагийн	ш	10
79	Трубка №3,5	Нэг удаагийн	ш	10
80	Трубка №3,0	Нэг удаагийн	ш	10
81	Трубка №2,5	Нэг удаагийн	ш	10
82	Трубка №2,0	Нэг удаагийн	ш	10
83	Ларингаль маск №5 №3	Нэг удаагийн	ш	3
84	Ларингаль маск №2,5	Нэг удаагийн	ш	10
85	Ларингаль маск № 2,0	Нэг удаагийн	ш	10
86	Ларингаль маск №1 № 1.5	Нэг удаагийн	ш	10
87	Амбуны маск	Нэг удаагийн	ш	10
88	Амбу /том/	Нэг удаагийн	ш	3
89	Амбу /хүүхдийн/	Нэг удаагийн	ш	1
90	Хэл дарагч	Нэг удаагийн	ш	10
91	Хүчилтөрөгч гуурс	Нэг удаагийн	ш	20
92	Ларингоскоп / гар/	Нэг удаагийн	ш	5
93	Мэс заслын бээлий	Нэг удаагийн	ш	30
94	Электрод	Нэг удаагийн	ш	50
95	Амьсгалын хүрээ гуурс	Нэг удаагийн	ш	20
96	Фильтер	Нэг удаагийн	ш	30
97	Тамедин 7,5%	Нэг удаагийн	ш	3
98	Хлоргексидин уусмал -0,05%-100,0	Нэг удаагийн	ш	3
99	Төв венийн гуурс	Нэг удаагийн	ш	4
100	Малгай	Нэг удаагийн	Ш	20
101	Маск	Нэг удаагийн	Ш	20

9.3 Сэрээх өрөө болон мэдээгүйжүүлгийн байх тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Тоног төхөөрөмжийн нэрс	Байх ёстой тоо ширхэг
1.	Ор	2
2.	Унтуулгын аппарат	5
4	Монитор	5
5	Дуслын памп	2
6	Шахуургын памп	3
7	Ханын нэгдсэн систем / хүчилтөрөгч, соруулга/	5
8	Штатив	5
10	Яаралтай тэргэнцэр	5
12	Дефибрилятор	1
13	Эхо	1
14	Зүрхний бичлэг хийх аппарат	1



Бүсийн оношилгоо
эмчилгээний төв



МЭС ЗАСЛЫН ӨМНӨ ӨВЧТӨНГ ШАЛГАХ ХУУДАС

/Time out Check off sheet /

Өвчтөний овог/нэр: Нас:..... Хүйс:.....

Өвчний түүхийн дуаар: жин/өндөр..... Тасгийн нэр:

Мэс засалд орох төлөвлөсөн өдөр:

Мэс засалд орсон өдөр: цаг:.....

Мэс заслын нэр:

№	Шалгах үзүүлэлт	Хэн шалгах	
		Хэвтэн эмчлүүлж буй тасаг	Мэс засал эхлэхийн өмнө
1	Мэс заслын зөвшөөрөл авсах эсэх	тийм/үгүй	тийм/үгүй
2	Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх зөвшөөрлийн хуудас	тийм/үгүй	тийм/үгүй
3	Мэс засал хийх талбай тэмдэглэсэн эсэх	тийм/үгүй	тийм/үгүй
4	Мэс заслын өвчтөнд танилцуулсан эсэх	тийм/үгүй	тийм/үгүй
5	Өвчтөн харшилтай эсэх	тийм/үгүй	тийм/үгүй
6	Мэс заслын өмнөх өвчин намдаалт	тийм/үгүй	тийм/үгүй
7	Хоол сойсон эсэх	тийм/үгүй	тийм/үгүй
8	Шээлгүүр /шаардлагатай бол /	тийм/үгүй	тийм/үгүй
9	Мэс заслын өмнөх шинжилгээ	тийм/үгүй	тийм/үгүй
10	Мэс заслын үед нэмэлтээр хэрэглэх тоног төхөөрөмжийн нэр		
11	Мэс заслын хүрц		
12	Мэс заслын ширээ	тийм/үгүй	тийм/үгүй
13	Өвчтөний байрлал		
14	Шаардлагатай багаж бэлтгэгдсэн эсэх	тийм/үгүй	тийм/үгүй
15	Шарханд урсгуур, гуурс шаардлагатай эсэх	тийм/үгүй	тийм/үгүй
16	Мэс заслын өмнөх антибиотик	тийм/үгүй	тийм/үгүй
17	Мэс заслын дараах эмчилгээ		
18	Бусад		

Мэс заслын эмч нар:

Мэс заслын сувилагч:

Мэдээгүйжүүлгийн эмч нар:

Мэдээгүйжүүлгийн сувилагч:

Тоног төхөөрөмжийн инженер:

Он сар өдөр: